

ТӨВ АЙМГИЙН 2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2023 оны 06 сарын 05-ны өдөр

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2023 оны 05 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

НЭГ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн ИТХ, Ажлын албанаас 2023 оны 05 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

-Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн ээлжит бус II Хуралдаанаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ээлжит бус 2 дугаар Хуралдаан 5-р сарын 04-ний өдөр хуралдаж дараах асуудлыг хэлэлцлээ. Үүнд:

1.Аймгийн ИТХ-ын 2023 оны 14 дүгээр хуралдааны 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн явц буюу Төв аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн бэлтгэл ажлын явцын тухай болон аймгийн хэмжээнд хийгдэж буй бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ажлын явцын мэдээллийг хэлэлцээд үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар аймгийн Засаг даргад албан бичиг хүргүүлэв.

2. Аймгийн ИТХ-ын ээлжит бус 4 дүгээр хуралдаанаар хэлэлцсэн Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс өгсөн хандив, тусламжийн хөрөнгийг төвлөрүүлэх, хуваарилах, зарцуулах журам батлах тухай асуудал дээр гарсан санал Хамтарсан ажлын хэсэг байгуулах байгуулах тухай

4.Аймаг сумдын ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах нэгдсэн сургалт зохион байгуулах талаарх мэдээллийг хэлэлцээд 06-р сарын 22-ны өдөр зохион байгуулахаар тогтов.

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн ээлжит бус III Хуралдаанаар:

Аймгийн Засаг даргын 2023 оны 05-р сарын 25-ны өдрийн 01/994 тоот албан бичгээр “Цэргийн албыг биеэр дүйцүүлэх албаны хяналтын тоо батлуулах тухай” асуудлыг хэлэлцүүлэх тухай өргөн мэдүүлснийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ээлжит бус 3 дугаар Хуралдаан 5-р сарын 24-ний өдөр хуралдаж Хурлын Хуралдаанд шилжүүллээ.

Тус асуудал хэлэлцэхтэй холбогдуулан аймгийн ИТХ-ын ээлжит 15 дугаар Хуралдааны товыг 2023 оны 05-р сарын 30-ны өдөр аймгийн ЗДТГ-ын “Соёмбо” танхимд цахимаар хуралдуулахаар шийдвэрлэв.

Аймгийн ИТХ-ын ээлжит бус V Хуралдаанаар:

Аймгийн ИТХ-ын V Хуралдаан 2022 оны 05-р сарын 30-ны өдөр 56.09 хувийн ирцтэй цахимаар хуралдлаа. Хуралдаанаар:

1.Цэргийн дүйцүүлэх албаны хяналтын тоо батлах тухай асуудлыг хэлэлцээд 2023 онд сумдад алба хаах иргэдийн хяналтын тоог 7 сум 60 иргэнээр тогтоон, сургалтад шаардлагатай зардлыг тогтоолоор баталлаа.

Аймгийн ИТХ-ын Ажлын албаны хүрээнд:

5 дугаар сард аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандсан 36 албан бичиг ирснийг бүртгэн авч хариу хүргүүлэх шаардлагатай 5 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн. Аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандан иргэдээс 3 өргөдөл, хүсэлт ирүүлснийг бүртгэн авч 2 өргөдлийн хариуг хуулийн хугацаанд хүргүүлэн, 1 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, сумын төлөөлөгчдийг чадавхжуулах сургалт 5 сарын 5-нд Цээл суманд зохион байгуулж, баруун бүсийн сумд болон аймгийн ИТХ-ын ажлын алба оролцлоо. Сургалтын дараа сумдын ИТХ-ын Төлөөлөгчдийн дунд спортын 3 төрөлт нөхөрсөг тэмцээн зохион байгууллаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал “Чанарын менежментийн тогтолцоо” ISO 9001:2015 стандарт хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд 2023 оны 05-р сарын 05-нд ISO стандартын ойлголт өгөх анхан шатны сургалтыг Стандартчилал хэмжилзүйн газраар хийлгэв. Сургалтад аймгийн ИТХ-ын Ажлын алба, Хороодын дарга нар, Зөвлөлийн гишүүд хамрагдлаа.

Мөн тус ажлын хүрээнд Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 05-р сарын 15-нд “Менежмент ба ур чадварын хүрээлэн” ТББ-тай “Чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх хамтын ажиллагааны санамж бичиг”-т гарын үсэг зурах үйл ажиллагаа зохион байгуулав.

ЗГХЭГ, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын институцийн чадавхыг бэхжүүлэх нь” төслөөс 05-р сарын 12-нд 21 аймгийн khural.mn хариуцсан мэргэжилтэнүүдэд сайтын

шинэчлэлт хөгжүүлэлтийн талаар сургалт зохион байгуулж, сургалтад Ажлын албаны ЗБИОНХХ-ийн дарга болон холбогдох мэргэжилтэн хамрагдлаа.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын хэсэг 05-р сарын 24-25-ны өдрүүдэд Төв аймагт ажиллаж, зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад аймгийн ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, хэлтсийн дарга нар хамрагдлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 53 дугаар зарлигаар Төв аймгийн 27 сумын харъяат 304 эхийг “Алдарт эх” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнасан тул шагнал гардуулах ёслолын ажиллагааг 2023 оны 05-р сарын 29-ний өдөр Монгол туургатан театрт аймгийн ИТХ-ын Ажлын алба, ЗДТГ хамтран зохион байгууллаа.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын хүрээнд:-

Төв аймгийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Боловсрол, шинжлэх ухааны газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газар, Замын цагдаагийн тасаг, МУЗН-ийн Төв аймаг дахь салбар хамтран сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дунд “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээнийг 05-р сарын 15-ны өдөр зохион байгуулав.

Сургуулийн өмнөх насны хүүхэд, эцэг эхчүүдэд замын хөдөлгөөнд оролцох зөв дадал олгох, хэвшүүлэх, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, дүрмийн мэдлэг олгох, сурталчлах зорилго бүхий уг тэмцээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 22 цэцэрлэгийн 220 хүүхэд багачууд, эцэг эх, багш нар оролцож, авхаалж самбаа, ур чадвараа сорин өрсөлдлөө.

Мөн хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг “Хүн бүр байгаль хамгаалагч” уриатайгаар 2023 оны 04 сарын 17-оос 05 сарын 17-ны хооронд зохион байгуулж тайланг холбогдох газарт хүргүүлэв.

Авлигатай тэмцэх газраас Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх таван ажиллагаа”-ны нэг “Шүгэл ажиллагаа”-ны хүрээнд авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан соён гэгээрүүлэх аяныг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс аймгийн хэмжээнд эхлүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, сумын төлөөлөгчдийг чадавхжуулах баруун бүсийн сургалтыг 2023 оны 05 сарын 05-ны өдөр зохион байгуулж, авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх талаар мэдээллийг хүргэлээ.

Төв аймгийн Алтанбулаг, Баянхангай сумдын хэсгийн төлөөлөгчдөд авто тээврийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор драгер хүлээлгэж өгсөн.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах аймгийн салбар комиссын ажлын хүрээнд:

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийн гэр бүл, үр хүүхэд, ач зээ зэрэг 27 сумын 333 хүний судалгаа гарган нэгтгэж, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст хүргүүлэв. Мөн хэлмэгдэгч Д.Сүрэнхорлоогийн нэхэмжлэгч Д.Мядагмаад 5 сарын 15-нд 80.0 сая төгрөгийн нөхөх олговор олголоо.

ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлыг 5 сард 1 удаа зохион байгуулж, 9 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхай зөвлөгөөнийг оны эхэнд батлагдсан хуваарийн дагуу 05 дугаар сарын 22-ны өдөр танхимаар зохион байгуулж, холбогдох үүрэг даалгавар өглөө.

“Иргэдтэй уулзах цаг” арга хэмжээг 2023 онд зохион байгуулах хуваарийн дагуу 05 дугаар сарын 03-ны өдөр аймгийн Үйлчилгээний нэгдсэн төвд аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга С.Магнайбаяр оролцлоо.

Аймаг, сумын хэмжээнд төрийн одон медальд тодорхойлогдсон 122 иргэний тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Ерөнхийлөгчийн тамгын газарт уламжлав.

ЗГХЭГ-аас томилогдсон ажлын хэсгээс зохион байгуулсан “Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт”-ийн хэлэлцүүлгийг аймгийн Монгол туургатан театрт зохион байгуулж 310 хүний саналыг санал асуулгын хуудсаар нэгтгэн ЗГХЭГ-ын төлөөлөгчид хүлээлгэн өгсөн.

Аймгийн харилцаат муж, хотуудад Төв аймаг байгуудагдсаны 100 жилийн ойн баярт хүрэлцэн ирэх урилга хүргүүлэв.

БНСУ-ын Инчеон хотын Эрүүл мэндийн газар, Аялал жуулчлалын газрын хамтарсан аялалын багийг аймагтх хүлээн авч аймгийн удирдлагуудтай уулзав. Айлчлалын хүрээнд

аймгийн Нэгдсэн эмнэлэг болон Инчеон хотын Хангил нүдний эмнэлэгтэй цаашид хамтран ажиллах санамж бичгийг байгууллаа.

Аймгийн түүхт 100 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах 12 салбар хороо, 3 дэд хороог аймгийн Засаг даргын 2023.05.16-ны а/329 дугаар захирамжаар томилж салбар хороодын төлөвлөгөө төсвийг батлуулах ажлыг зохион байгуулсан. Салбар хороодын шуурхай хуралдааныг долоо хоног бүрийн лхагва гариг бүрт зохион байгуулж нийт 3 удаа хийж, үүрэг чиглэл өгөв.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/392 дугаар захирамжаар аймгийн 100 жилийн баяр наадмыг зохион байгуулах салбар хороодын төсвийг баталсан.

Аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн бэлтгэл ажлын хүрээнд “Төв 100” пэйж хуудсыг нээн ажилуулж байна. Тус пэйжид тайлант хугацаанд 236 төрлийн мэдээлэл орж, давхардсан тоогоор 260,000 гаруй хандалт аваад байна.

2023 онд хамтран ажиллахаар 5 тв, 3 сайт, 2 өдөр тутмын сонинтой хамтран ажиллах гэрээ байгуулсан. Төв аймаг/tuv province пэйж хуудсаар дамжуулан 27 сумын танилцуулга, “Хэн юу хэлэв” цуврал фостер, “Төв аймагчууд түүхийн хуудаснаа”, “Ардын төрийн наадамд Төв аймагчууд”, “Өнөөдөр түүхийн хуудаснаа Төв аймаг” зэрэг цуврал постеруудыг бэлтгэн түгээн ажиллаж байна.

Мөн аймгийн хэмжээнд хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудыг иргэдэд сурталчих чиглэлээр 129 удаагийн мэдээ мэдээллийг бэлтгэн түгээсэн. Төв аймгийн 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан “Төв түмний золголт”, “Төв түмний аварга малчид” зөвлөгөөн, Төв түмний хүлэгч” зөвлөгөөн болон улсын болон олон улсын чанартай спортын тэмцээн уралдаанаас “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн 2 дугаарыг бэлтгэн нэвтрүүлээ.

Төв ТВ, ХХААГ-тай хамтран “Төв түмний аваргууд” нэвтрүүлгийн 29 дугаар хийсэн. Мөн Төв аймгаас төрөн гарсан алдар гавъяатнуудын талаар нэвтрүүлгийн зураг авалтыг хийгээд байна. ТБС телевизтэй хамтран “Төв нутгийн 100 жилийн түүхэн замнал” нэвтрүүлгийн 32 дугаарыг бэлтгэн нэвтрүүлээд байна.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВИЙН ХҮРЭЭНД:

2023 оны 05 дугаар сард аймгийн Үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт **16** байгууллага **600-аад** төрлийн үйлчилгээг **6300 гаруй** иргэнд, өдөрт дунджаар **250-300** иргэнд хүргэн үйлчилжээ.

Цахим үйлчилгээний нэгдсэн систем /www.e-mongolia.mn/-ээр дамжуулан аймгийн хэмжээнд **1414** лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ҮНТөвийн операторуудаас **763** лавлагаа үйлчилгээ авсан байна. Мөн E-Mongolia үйлчилгээний тухай заавар зөвлөмжийг, төрийн үйлчилгээг цахимаар авч болох тухай мэдээ мэдээллийг **95** иргэнд хүргэж ажилласан байна.

Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд **4** гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжилсан.

Өөрөө өөртөө үйлчлэх цахим мэдээллийн буланд иргэд өөртөө үйлчлэх зориулалт бүхий газрын албаны киоск машин, төлбөр төлөлтийн “Гэрэгэ” киоск машинуудыг байршуулсан. Мөн Цахим үйлчилгээний нэгдсэн систем www.e-mongolia.mn, Газрын мэдээллийн нэгдсэн сангийн www.egazar.gov.mn, Аймгийн албан ёсны веб сайт www.tov.gov.mn, Аймгийн статистикийн хэлтсийн www.nso.gov.mn сайтуудыг холбосон 4 ухаалаг дэлгэцийг тус тус байршуулан иргэдэд цаг үеийн болон дотоод ажил үйлчилгээтэй холбоотой мэдээ мэдээллийг тогтмол хүргэж байгаа бөгөөд газрын нэгдсэн систем болох www.egazar.gov.mn сайтаар дамжуулан нийт **172** иргэн газрын талаарх үйлчилгээ авсан бол Гэрэгэ киоскоор дамжуулан **57** иргэн машины татвар, торгууль, улсын бүртгэлийн лавлагаа, жолоочын хариуцлагын даатгал, үүрэн телефоны нэгж авах зэрэг үйлчилгээнүүдийг авчээ.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг даргын Монгол Улсын Шадар Сайдтай 2023 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор “Гамшгаас хамгаалах команд штабын сургууль”-ийг аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/290 дүгээр захирамжийн дагуу Заамар суманд зохион байгуулж явуулсан.

Стратегийн команд штабын сургуулийн хүрээнд Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн “Ажиллагааны удирдлагын бүрэлдэхүүнийг томилох тухай” А/323 дугаар захирамжаар аймгийн штабын бүрэлдэхүүнд 74 албан хаагчийг томилгоожуулж ажиллагааны удирдлагын бүрэлдэхүүнд ослын удирдлагын тогтолцоо, стратегийн команд

штабын сургуулийн үед хийгдэх ажлын талаар 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр сургалт зохион байгуулсан.

Терроризмтой тэмцэх зөвлөлийн Төв аймаг дахь Салбар зөвлөл нь үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх чадавхыг дээшлүүлэх, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд “Хаан шонхор-2023” дадлага сургуулийг Төв аймгийн Сэргэлэн сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Чингис хаан” Олон Улсын нисэх буудалд 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан.

Монгол Улсын шадар Сайдын баталсан “Төр захиргааны байгууллагын барилга байгууламжид гамшгаас хамгаалах, галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулах удирдамж” нэгдсэн удирдамжийн хүрээнд гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2023 оны 05 сарын 22-31-ний хугацаанд зохион байгуулж Зуунмод сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Төр захиргааны нийт 10 байгууллага хамрагдсанаас гал түймэр, аюулт үзэгдэл, ослын аюулд хүргэж болзошгүй 16 зөрчил илэрсэн. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн танилцуулга 1-г хүргүүлэн, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж сургалт заавар зөвлөгөө өгч ажиллав.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Ногоон бүсийн айл өрх, амралтын газар, жуулчны баазын барилга, байгууламжид гамшгаас хамгаалах, галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулах удирдамж”, Онцгой байдлын газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний баталсан “Жуулчны бааз, амралтын газар, музей, зочид буудал, зоогийн газруудад гамшгаас хамгаалах, галын аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамж”-ийн хүрээнд Аргалант, Батсүмбэр, Баянчандмань, Борнуур, Эрдэнэ сумдад, жуулчны бааз, амралтын газрын үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжид Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, холбогдох дүрэм, стандарт, норм, нормативын хэрэгжилтийг хангуулах зорилгоор төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2023 оны 05 дугаар сарын 01-22-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Хяналт шалгалтаар 37 ногоон бүсийн иргэн, хуулийн этгээдийн барилга, байгууламжийг хамруулан нийт 233 зөрчил дутагдлыг илрүүлж, газар дээр нь 54 зөрчлийг арилгуулж, бусад 179 зөрчил дутагдлуудыг арилгуулахаар 37-н Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлагыг шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн захирал, удирдлага нарт хүргүүлж, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр мэргэжил арга зүйн заавар, зөвлөмж өгч ажиллав.

Онцгой байдлын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар Батсүмбэр, Эрдэнэ, Мөнгөнморьт сумдад ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор хяналтын постод нийт 16 алба хаагч, 3 автомашинтай 32 ширхэг багаж хэрэгсэлтэйгээр 14 хоногийн хугацаатай ажиллуулсан.

Аймгийн Засаг даргын Монгол Улсын Шадар Сайдтай 2023 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор “Гамшгаас хамгаалах команд штабын сургууль”-ийг аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/290 дүгээр захирамжийн дагуу Заамар суманд Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Мал эмнэлгийн газар, Улаанзагалмайн анхан шатны хороотой хамтран сумдын Онцгой комисс, ерөнхий зориулалттай мэргэжлийн анги, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэд Эрдэнэсант, Угтаалцайдам, Лүн, Өндөрширээт, Баянцогт сумдын Онцгой комисс, удирдах бүрэлдэхүүнийг хамруулан зохион байгууллаа.

Заамар суманд зохион байгуулагдсан “Гамшгаас хамгаалах команд штабын сургууль”-д сумдын мэргэжлийн ангийн 7 бүлгийн 72 томилгоот бүрэлдэхүүн, 5 сумын 35 удирдах бүрэлдэхүүн, ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн 579 сурагч, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 215 хүүхэд, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн 112 ажилтан, 121 иргэнд танхимын сургалтыг зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийг сурталчлан 8 төрлийн 1589 ширхэг гарын авлага, тараах материалыг тараан ажилласан. Нийт 16 цагийн танхимын сургалтаар 1134 иргэнийг хамруулсан. Гамшгаас хамгаалах команд штабын сургуульд Заамар сум 88,2 хувь буюу “Хангалттай” үнэлгээтэйгээр дүгнэгдсэн.

Аюулт үзэгдэл, ослын төрөл тус бүрд урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах талаар онол, практикийн мэдлэг, чадвартай алба хаагчдыг бэлтгэх зорилгоор ангиллын сургалт зохион байгуулах удирдамж гарган батлуулж, Онцгой байдлын газрын урьдчилан сэргийлэх тасгийн алба хаагчид, мэргэжилтэн нартай хамтран ангиллын сургалтыг танхим,

дадлага хэлбэрээр зохион байгуулж 14 удаагийн 26 цагийн сургалтаар 1351 хүнийг хамрууллаа.

Цаг агаарын мэдээг орон нутгийн хэмжээнд нарийвчлан тодруулж, өвөлжилт, хаваржилт хүндрэх болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, малчид, аж ахуйн нэгж байгууллагад шуурхай хүргэх ажлыг зохион байгууллаа. Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газар, Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтран багц мессежийг 27 сумын хэмжээнд 8569 иргэнд, байгууллагын цахим хуудас, фейсбүүк хаягаар 36987 иргэнд, нийт 45556 иргэнд цаг агаарын анхааруулах болон сэрэмжлүүлэг мэдээллийг тухай бүр хүргэн ажилласан.

Онцгой байдлын цахим хуудсанд цаг агаарын сэрэмжлүүлэх мэдээний постер 7 төрөл, шторк 6, анхааруулга мэдээг 13, сэрэмжлүүлэг мэдээг 32, нийт 45 удаагийн байгууллагын цахим хаяг, 27 сумын мэдээллийн группт байршуулахад нийт 69758 хандалт авсан байна.

Ой, хээрийн гал түймэр-1, Объектын гал түймэр-12, Мал, амьтны гоц халдварт өвчин-5, авто осол-1, эрэн хайх-2, усны осол-1 нийт 22 дуудлага, мэдээлэл хүлээн авч, гал түймэр унтраах, эрэн хайх аврах, хор уршиг арилгах үйл ажиллагаанд онцгой байдлын газраас давхардсан тоогоор 40 алба хаагч, 7 техник, орон нутгийн иргэд-286, 45 техниктэй аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүх болон сумд дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд аймгийн Засаг даргыг төлөөлж 3 удаагийн шүүх хуралд оролцлоо.

Аймгийн Засаг даргын 63 захирамж, 4 гэрээний хууль зүйн үндэслэлийг хянаж зөвлөгөө өглөө.

Монгол улсын анхдугаар Үндсэн хуулийн 100 жилийн ойг угтан Үндсэн хуулийн үзэл баримтлалыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, Үндсэн хуулийн хэрэглээг нэмэгдүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр "Иргэдийн шударга шүүх" төрийн бус байгууллагатай хамтран 27 суманд тус бүр 2 сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж 54 иргэнийг чадавхжууллаа.

Монгол Улсын Засгийн газрын "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг эрчимжүүлэх чиглэлээр Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран сум, баг, байгууллагад "Эрх зүйн хөтөч" бэлтгэх, давтан сургах, чадавхжуулах сургалтад танхим болон цахимаар хамрагдсан 149 албан хаагчдад эрх зүйн хөтчийн гэрчилгээг цахимаар олгосон.

Монгол улсын Терроризмтой тэмцэх зөвлөл, Төв аймаг дахь салбар зөвлөлөөс "Чингис хаан" Олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны дадлага сургуулилтыг төрийн болон хууль сахиулах байгууллагатай хамтран зохион байгууллаа. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны дадлага сургуулилт нь Монгол Улсад террорист үйлдэл гарсан тохиолдолд Терроризмтой тэмцэх зөвлөлийн гишүүн байгууллагууд болон бусад холбогдох төрийн байгууллагуудын харилцан уялдаа, бэлэн байдлыг хангах чухал ач холбогдолтой юм.

Нутгийн захиргааны байгууллага болон Хууль зүйн салбарын "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг Төв аймгийн Зуунмод суманд 05 дугаар сарын 1-ний өдөр, 05 дугаар сарын 11-ний өдөр Заамар сумын Хайлааст 3 дугаар багт тус тус зохион байгуулж Шүүх, Прокуро, Цагдаа, Шийдвэр, Шинжилгээ, Улсын бүртгэл болон газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хүний эрхийн Үндэсний комиссын Төв аймаг дахь салбар, Хууль зүйн туслалцааны төвийн Төв аймаг дахь салбар Зуунмод, Заамар сумын Засаг даргын Тамгын газар хамтран төрийн 20 гаруй оролцон 47 төрлийн үйлчилгээг 680 иргэнд үзүүлж, хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа. Мөн Заамар сумын Хайлааст 3 дугаар багт зохион байгуулсан өдөрлөгийн үеэр Төв аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн хэрэгт "Нээлттэй шүүх хурал" зохион байгуулж иргэдэд шүүн таслах ажлыг ойртууллаа. Түүнчлэн Хүний эрхийн Үндэсний комиссын Төв аймаг дахь салбар, Хуульчдын холбоотой хамтран Ерөнхий боловсролын сургуулийн 9-11 дүгээр ангийн 135 сурагчийн дунд эрх зүйн сургалт зохион байгууллаа.

Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс Төв аймгийн Шүүхийн байгууллагын үйл ажиллагаатай танилцлаа. Шүүх, хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд Нутгийн удирдлагын байгууллагатай хамтран ажиллах хүрээнд эрх зүйн шинэтгэлийн ажлыг орон нутагт эрчимжүүлэхэд хамтын ажиллагаагаа уялдуулах, иргэдэд бүх нийтийн эрх зүйн боловсрол олгох ажилд ахиц гаргах, хууль зүйн салбарт ажиллаж буй хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх, тогтвортой ажиллуулах чиглэлээр нийгмийн баталгааг хангах, хямд өртөг бүхий орон сууц, түрээсний

хөтөлбөрт хамруулах, шүүхийн байгууллагын ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад хамтран ажиллахаа илэрхийллээ. Мөн орон нутагт ажиллаж буй эрх зүйн мэргэжилтэн, бусад төрийн албан хаагчдыг шүүхийн үйл ажиллагаатай танилцуулах, мэргэжлийн онцлогоос шалтгаалсан дадлажуулах сургалт, оролцооны ажлыг үе шаттай хэрэгжүүлэхээр болоод байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Стратеги судалгааны хүрээлэнгээс ажлын хэсэг Төв аймагт ирж 2023 оны 05 дугаар сарын 24-өөс 25-ны өдрүүдэд ажиллалаа. Ажлын хэсэг нутгийн удирдлагын байгууллага болон зарим тусгай чиг үүргийн байгууллагад шалган танилцах ажлыг зохион байгуулж, төрийн болон тусгай чиг үүргийн байгууллагуудын удирдлагууд, төрийн албан хаагч нийт 30 байгууллагын 70 гаруй хүнд сургалт зохион байгуулж арга зүйн дэмжлэг үзүүллээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар ээлжит 15 дугаар хуралдаанаар захиргааны хэм хэмжээний актыг шинэчлэн батлах, улсын нэгдсэн санд бүртгүүлж, ИТХ-аар хэлэлцүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийт 12 тогтоолыг 06 дугаар сарын 30-ны хуралдаанаар хэлэлцүүлэх тул холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн, өөрчлөлтийг тусган боловсруулж Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.4, 61.6 дахь хэсэгт заасны дагуу нөлөөллийн шинжилгээ, мөн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэгт заасны дагуу төсөлд нийтийн саналыг тусгах зэргээр хэлэлцүүлэг хийх, байгууллагын албан ёсны вэб сайтад байршуулж санал авах ажлыг зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 17 дугаар тэмдэглэлээр бүх шатны Засаг дарга нарт Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг үүрэг болгосны дагуу аймгийн хэмжээнд Хүний эрхийн төлөв байдлын 2022 оны тайланд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлжээ.

Авлигатай тэмцэх газраас “Шүгэл ажиллагаан”-ны хүрээнд хэрэгжүүлж буй “Нэгдье” аянд нэгдэж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран иргэдэд сурталчлах ажлыг зохион байгууллаа.

Төв аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд Халхын түшээт хан аймгийн тамганы танилцуулгыг аймгийн Хэвлэл мэдээллийн албатай хамтран бэлтгэн олон нийтэд сурталчиллаа.

Төв аймгийн Номын сан Заамар сумын Хайлааст багийн Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Эрдэнэ сумын МСҮТ-ийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд зөвлөн тусалж арга зүйн дэмжлэг үзүүллээ

. Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагуудын Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад “Байгууллагын архивын нийтлэг журам” сэдвээр цахим сургалтыг зохион байгуулж, 67 албан хаагчдыг хамрууллаа. Төрийн байгууллагуудад “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, “Байгууллагын архивын нийтлэг журам”-аар 3 подкаст бэлтгэн хүргэлээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр “Шил ажиллагаа”-ны хэрэгжүүлэлтийг эрчимжүүлэх тухай албан даалгаврын 1,2-д тусгагдсан Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2008-2018 оны аймгийн болон 27 суманд баригдсан барилга байгууламжийн улсын комиссын дүгнэлтийг Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газартай хамтран Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа 76 дугаар хөмрөгийн 308 баримтад судалгаа хийж дүгнэлт гаргаж цахим мэдээллийн санд орууллаа.

ТӨРИЙН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР

Байгууллага, иргэдийн хүсэлтийн дагуу 177 иргэний хүсэлтийг хүлээн авч 924 хуулбар хувь олгож, 68 лавлагаа, 234 хөмрөгийн 650 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан лавлагаа, хуулбарын үйлчилгээ үзүүлж 501,000 төгрөгийг орон төсөвт орууллаа.

Нэг хөмрөгийн 163 хадгаламжийн нэгжийн 2980 хуудас баримтын 2778 заалтын тоо, 2778 тушаалын тоо, 18208 хүний нэрийг мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивэж, 1 хөмрөгийн 2778 заалтыг PDF, JPEG хэлбэрт хувиргаж, 2778 заалтын 2778 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэлээ.

Баримтын нөхөн бүрдүүлэлтээр 2 хөмрөгийн 33 хадгаламжийн нэгжийг хүлээж авч хүлээн авч, бүртгэлээ.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 67355 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 138852 газар өмчлөх эрхийн 55234 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 1938 /5 сард хүлээн авсан мэдүүлэг 1938

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 230 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос 3434,3 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 111,8 сая төгрөг, тэмдэгтийн хураамжаас 2,8 сая төгрөгийг улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 3005 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 152 нэмэлт өөрчлөлт, шинээр 88 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 2, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 32 бүртгэл хийгдсэн. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 45 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 96 лавлагаа өгч, Хуулийн этгээдийн бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн орлого 26,5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2023 оны 05 дугаар сард 211 гэмт хэрэг бүртгэгдсэн нь -145 хэргээр буюу -40,7 хувиар буурсан, Гэмт хэргийн илрүүлэлт 44 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,2 хувиар өссөн байна.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа:

Эрүүлжүүлэх, саатуулах байранд гудамж талбай олон нийтийн газар ухаангүй унасан, ар гэртээ согтуугаар танхайрсан зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн-9, шүүхээр баривчлагдсан-74, албадан саатуулсан-9, ар гэрт нь 19 иргэнийг хүлээлгэн өгч, нийт 119 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд код журмын дагуу биед эрүүл мэндийн үзлэг хийж, хүлээн авч ажиллалаа.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Тус цагдаагийн газраас Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр Франц Улсын Ерөнхийлөгч Эммануел Макрон болон Польш Улсын Ерөнхийлөгч Анджей Дуда нар Монгол улсад айлчлах үеийн хамгаалалт, Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Төв аймгийн Баянчандмань, Борнуур суманд ажиллах үеийн хамгаалалтад, Сэргэлэн сумын нутаг Хөшгийн хөндийн Нисэх онгоцны буудалд дээр зохион байгуулсан Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны дадлага сургуулилтад мөн Төв аймгийн Зуунмод суманд зохион байгуулагдсан “Соёлын сэргэлт” аяны хүрээнд зохион байгуулсан урлагийн тоглолтын хамгаалалтуудад давхардсан тоогоор 150 алба хаагч, 25 автомашин, 100 тусгай хэрэгсэл, 15 холбооны хэрэгсэл, ашиглаж 125 цагийн үүрэг гүйцэтгэж ажилласан. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хариуцсан нутаг дэвсгийн хэмжээнд “Электрон тамхины хор нөлөө”, “Төгсөлт”, “Эргүүл хяналт”, “Үзлэг шалгалт” “Хяналт 2023” зэрэг тусгай болон хэсэгчилсэн хяналт шалгалтуудыг зохион байгууллаа.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гудамж замын хяналт шалгалтаар 6470 зөрчил илрүүлж, Монгол улсын Зөрчлийн тухай хууль ийн 14.7 дугаар зүйлийн 3.1, 5 дахь заалтуудыг зөрчиж согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 92 жолоочийг илрүүлэн тээврийн хэрэгслийг түр саатуулсан.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 68 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, хуульд заасны дагуу 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон 24 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэвэрээр 7-30 хоног баривчилуулж, Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 57 жолоочийг илрүүлж, Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд мэдээллийг бүртгэлээ.

Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 6321 жолоочийг 153,6 сая төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 149 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатууллаа.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

Криминалистикийн шинжилгээ-64, магадлан шинжилгээ-83, хэргийн газрын үзлэгт оролцсон тоо-205, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-456, гарын хээний санг дардсаар баяжуулсан-147, мөрөөр баяжуулсан-46, гэмтлийн зэрэг тогтоосон дүгнэлт-310, ДНК-ийн мэдээллийн сангийн баяжилт-83, гистологийн шинжилгээ-83 хийгдлээ.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Дундаж хувь
05-р сар	309	249	28	202	328	38.11
	4857937.6	2893129.1	239044.2	1600691.7	5911330.8	

ДӨРӨВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2 дахь заалтын дагуу хяналт-шинжилгээ хийхэд

1. Аймгийн “Газар тариалангийн үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого”-ын II үе шат (2021-2024 он)-ны 9 зорилт 82 арга хэмжээний 2022 оны жилийн эцсийн хэрэгжилт 85.38 хувьтай буюу “ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРСЭН” байна.

2. “Оюунлаг Төв аймаг” хөтөлбөрийн 5 зорилт 26 арга хэмжээний 2022 оны жилийн эцсийн хэрэгжилт 62.92 хувьтай буюу “ЭРЧИМЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ”

3. “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилт 23 хэрэгжүүлэх арга хэмжээ байдлаар Үр дүнтэй буюу 100 хувьтай 14, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-100 хувьтай 3, тодорхой үр дүн гарч эхэлсэн буюу 30-70 хувьтай 3, үр дүнгүй буюу 0 хувьтай 3 арга хэмжээ байгаа бөгөөд 2022 оны жилийн эцсийн дундаж үнэлгээ 75.21 хувьтай буюу “ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРСЭН”

4. “Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөөний 3 зорилт, 16 арга хэмжээ 2022 оны жилийн эцсийн байдлаар 77.35 хувь буюу “ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРСЭН” гэж дүгнэлээ. Үүнээс :

- Жимс, жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилтын 4 арга хэмжээ 95.06 хувь
- Хөтөлбөрийг олон нийтэд сурталчилах, иргэдийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, шинэ нэр төрлийн жимс, жимсгэний технологийг нэвтрүүлэх зорилтын 5 арга хэмжээ 80.0 хувь
- Хүн амыг экологийн цэвэр амин дэм бүхий жимс, жимсгэнээр хангахад үйлдвэрлэл эрхлэгч нарыг дэмжих зорилтын 7 арга хэмжээ 57 хувийн биелэлттэй тус тус дүгнэлээ.

5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу төлөвлөгөөг боловсруулахад чиглэгдсэн санал, зөвлөмж гаргаж Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлээд байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын чиглэлээр

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад ОНХС, ХХС, ЭЭС-ийн үйл ажиллагаанд дотоод аудит, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт шалгалт хийж 546,767.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 15530.2 мянган төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн акт, 537,402.8 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага өгч ажиллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Төв аймгийн Мэдээлэл сүлжээний газар, Монголын цахилгаан холбооны салбар, Монгол шуудан, Эрүүл мэндийн газар, Ойн ангиуд, Улсын бүртгэлийн хэлтэс байгууллагуудад санхүүгийн хяналт шалгалт хийж 2001.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлж санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн акт тогтоож ажиллалаа.

Сангийн яамны нэгдсэн удирдамжийн дагуу Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаа болон сангуудын 2021-2022 оны баримтуудад санхүүгийн хяналт шалгалт хийгдэж байна.

Эхний 5 сарын байдлаар: Нийт илрүүлсэн зөрчил- 554,934.6 мянган төгрөг үүнээс

- СХШУ-ын ахлах байцаагчийн акт – 17,531.8 мянган төгрөг
- СХШУ-ын ахлах байцаагчийн албан шаардлага - 537,402.8 мянган төгрөг

Өмнөх онуудын актын үлдэгдэл 190,473.4 мянган төгрөгийн актын үлдэгдлээс 25889.2 мянган төгрөг барагдаж үлдэгдэл 164584.2 мянган төгрөг байна.

ТАВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХҮРЭЭНД:

Төсвийн орлогын талаар:

Орлогын төлөвлөгөө 2023 оны 04 дүгээр сарын байдлаар орон нутаг 8,542.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 12,874.5 сая төгрөг төвлөрүүлж 150.7 хувьтай, 4,322.0 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө давсан байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 1,245.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 1,511.0 сая төгрөг төвлөрүүлж 121.3 хувьтай, 265.7 сая төгрөгөөр давж биелсэн. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлтийг нийт 5,213.9 сая төгрөгөөр давуулан биелүүлж, 145,3 хувьтай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөг биелүүлсэн 11 сум байна. Үүнд: Архуст, Батсүмбэр, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Заамар, Сүмбэр, Угтаал, Цээл, Эрдэнэсант, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Баяндэлгэр, Баянжаргалан, Баянцагаан, Лүн, Мөнгөнморьт, Өндөрширээт, Эрдэнэ, Зуунмод зэрэг 8 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Алтанбулаг, Аргалант, Баян, Баян-Өнжүүл, Баянхангай, Бүрэн, Дэлгэрхаан, Сэргэлэн зэрэг 7 сум байна. 3 шатны орлогын төлөвлөгөө тасалсан сум байхгүй.

Төсвийн зарлага, санхүүжилтийн талаар:

Аймгийн төсвөөс 2023 оны 04 дүгээр сарын байдлаар нийт 13,324.3 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн төсвийн байгууллага болон 27 суманд олгосон.

Зарлагыг салбараар авч үзвэл:

Боловсрол, шинжлэх ухааны байгууллага 5,211.0 сая төгрөг

Эрүүл мэндийн байгууллага 474.6 сая төгрөг

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбар 9,083.3 сая төгрөг

Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагууд 5,263.1 сая төгрөг, нийт 20,032.0 сая төгрөгийн зарлага гаргаад байна.

Өр, авлагын талаар:

2023 оны 04-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 316.2 сая төгрөгийн авлага, 384,1 сая төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 272.3 сая төгрөг буюу 68.9 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 0.6 сая төгрөг буюу 0.1 хувь нь цалингийн өглөг, 10.7 сая төгрөг буюу 2.9 хувь нь нийгмийн даатгалын шимтгэлийн өр, 46.9 сая төгрөг буюу 11.9 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, үлдсэн 64.9 сая төгрөг буюу 19.9 хувийг бусад өр эзэлж байна.

ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:

Аймгийн хэмжээнд 2023 онд **170.1 тэрбум** төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэхээр төлөвлөгдлөө. Үүнд:

- Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжих 143.9 тэрбум төгрөгөөр санхүүжих 49 төсөл, арга хэмжээ тусгагдаж 32 төсөл арга хэмжээний эрх шилжиж ирээд байна.
- Орон нутгийн хөгжлийн сангаар 7.6 тэрбум төгрөгийн 27 төсөл, арга хэмжээ
- Аймгийн төсвийн шилжих үлдэгдлийн хөрөнгө оруулалтаар 6.1 тэрбум төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ
- Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 1.2 тэрбум төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ
- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1.8 тэрбум төгрөгийн 8 барилга, их засвар
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 0.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 төсөл, арга хэмжээ
- 27 суманд хуваарилагдсан орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээр 8.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр тус тус тусгагдлаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 22,546.4 сая төгрөгийн 78 төсөл, хөтөлбөр, арга хэмжээг тусган баталж, үүнээс 17,103.7 сая төгрөгийн 62 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн. Нэмэлтээр: 2023 онд Боловсрол, шинжлэх ухааны сайдын шийдвэрээр 500.0 сая төгрөгийн 1 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх эрхийн шилжүүлсэн.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2023 онд зарлахаар 17,603.7 сая, төгрөгийн 63 төсөл, арга хэмжээг дараах байдлаар тендер шалгаруулалтыг нь зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Үүнд:

1. Орон нутгийн өмчийн газарт тендер шалгаруулалт зарлах 12,737.4 сая төгрөгийн 28 төсөл, хөтөлбөр, арга хэмжээ;

2. Сумдад эрх шилжүүлж, сумын ЗДТГ-т тендер шалгаруулалт зохион байгуулах 4,886.3 сая төгрөгийн 35 төсөл, арга хэмжээ.

Аймгийн Орон нутгийн өмчийн газарт зарлах тендер шалгаруулалтын явц:

2023 онд 12,737.4 сая төгрөгийн 28 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд ОНӨГ-аас тендер зарлахаас 05 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 11,928.1 сая төгрөгийн 23 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд үнэлгээний хороо байгуулагдаж тендерийн явц 82 хувьтай.

Сумдад эрх шилжүүлж, сумын ЗДТГ-т тендер шалгаруулалтын явц:

2023 онд 4,886.3 сая төгрөгийн 35 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд сумдад тендер зарлахаас 05 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 4,723.3 сая төгрөгийн 25 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд үнэлгээний хороо байгуулагдаж тендерийн явц 71 хувьтай.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын явц 76 хувьтай хэрэгжиж байна.

ХОЁР.БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн дулаан хангамжийн шугам сүлжээ, ус дулаан дамжуулах төв төлөвлөж байгаа трасстай газар давхардаж буй аж ахуй нэгжүүдтэй Барилга хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төвийн холбогдох мэргэжилтэнгүүд зөвшилцсөөд байна.

Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд нийт 2023 онд 38 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан баталсан ба энэ сард 9 архитектур төлөвлөлтийн даалгавар олгоод байна.

Зураг төсөл зөвшөөрөлцөх баталгаажуулах шатанд байршилыг ерөнхий төлөвлөгөөний хүрээнд батлах, орон нутгийн саналыг зурагт тусгах зэрэг ажлыг хийж гүйцэтгэж 5 сард 17 зураг төсөл батласанаар 2023 онд нийт 72 зураг төсөл зөвшөөрөлцөөд байна.

Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай албан даалгаврын 1.2-д тусгагдсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2008-2023 оны улсын комиссын дүгнэлтийг маягтын дагуу Газар зохион байгуулалт, Геодези, Зураг зүйн газарт хүргүүллээ.

Барилга эхлүүлэх зөвшөөрөл олгох ажлын хүрээнд нийт 2023 онд 28 зөвшөөрөл олгосноос энэ сард 10 зөвшөөрөл олгоод байна.

Барилга ашиглалтад оруулах үйл ажиллагааны хүрээнд нийт 2023 онд 20 барилга байгууламжийг ашиглалтад оруулсанаас энэ сард 9 барилга байгууламжийг ашиглалтад оруулаад байна.

Барилга хот байгуулалтын яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 02-00/06 дугаартай удирдамжийн дагуу Төв аймгийн Зуунмод сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт БЗОСК ОНӨААТҮГ-ын захиалгаар “Баяндөрвөлж” ХХК-ний гүйцэтгэж буй 160 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн дотуур байрны барилга, “Төвцогтөлзийт” ХХК-ийн гүйцэтгэж буй 42 айлын орон сууцны барилга, иргэн н.Хүрэлбаатарын захиалгаар “Нью прожект констракшн” ХХК-ийн гүйцэтгэж буй орон сууцны барилгын угралтын ажилд хамтарсан төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай улсын байцаагийн хамтарсан 4 заалттай 3 албан шаардлага боловсруулж хүргүүлж ажилласан. Албан шаардлагын хугацаа болоогүй байна.

2023 онд улсын хэмжээнд зохион байгуулсан өмчийн хэлбэр харгалзахгүй бүх төрлийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ашиглалтын төлөв байдалд хийх төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх тухай Барилга хот байгуулалтын яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 02-00/07 дугаартай удирдамжийн хүрээнд Төвчандмань ДЭХГ, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК Төв аймгийн газрын Зуунмод суманд ашиглагдаж буй эвдрэл гэмтэлтэй сувагчлалын болон дулааны худаг, худгийн тагны засвар үйлчилгээ, шинэчлэлтийн ажлыг гүйцэтгүүлэх тухай улсын байцаагийн хамтарсан 4 заалттай 2 албан шаардлага боловсруулж хүргүүлж ажилласан. Албан шаардлагын хугацаа болоогүй байна.

Барилга хот байгуулалтын яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 02-00/06 дугаартай удирдамжийн хүрээнд Борнуур суманд “Сайнконстракшн” ХХК-ийн гүйцэтгэж буй цэвэрлэх байгууламж, гадна шугам сүлжээний угсралтын ажилд хяналт шалгалт хийж, ИТА-д мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ажлын тэмдэглэлд үүрэг даалгавар өгсөн. Мөн Жаргалант сумын Тал булаг багт “Сэрвэн овоот” ХХК-ийн гүйцэтгэж буй Спорт заалны барилгын угсралтын ажилд инженерийг байлцуулан хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ажлын тэмдэглэлд үүрэг даалгавар өгч ажилласан.

ГУРАВ.ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг Аргалант сум 8 нэгж талбар, Борнуур сум 2 нэгж талбар, Мөнгөнморьт сум 10 нэгж талбар, нийт 20 нэгж талбарын дуудлага худалдааг газрын биржийн www.mle.mn сайтад баталгаажуулж, зарласан.

Газрын төлбөрийн нэхэмжлэл үүсээгүй татвар төлөгчөөр бүртгэгдээгүй, хөрөнгийн бүртгэл үүсээгүй 186 нэгж талбарт газрын төлбөрийн нэхэмжлэл үүсгэсэн.

2023.05.29-ний өдрийн байдлаар газрын төлбөрийн орлогоос 866,1 сая төгрөг аймаг, сумдын төсөвт төвлөрөөд байна.

Газрын дутуу төлөлтөөс 264,5 сая төгрөг төвлөрсөн. Газрын дуудлага худалдааны орлогоос 720,3 сая төгрөг төвлөрөөд байна.

Аймгийн 100 жилийн хүрээнд “Цэмцгэр хашаа” аян зарлаад 1, 6-р багийн нутагт 60 хашаа өнгө үзэмжээ сайжруулах шаардлагатай байгаагаас 30 хашаанд мэдэгдэл өгсөн байна.

Үүнээс 22 хашаа өнгө үзэмжээ сайжруулж модон хашаагаа өнгө үзэмжтэй төмөр хашаагаар солихоо мэдэгдсэн.

Аймаг, Нийслэлийн Захиргаа, Иргэний хэргийн анх шатны шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн албан бичгийн дагуу 24-н лавлагаа гаргаж хүргүүлсэн.

Нөхөн бүртгүүлэлт хийх шаардлагатай 6384 нэгж талбарын судалгааг сум тус бүрээр гаргаж нөхөн бүрдүүлэлтийг эрчимжүүлэх ажлыг 2023-05-01 ны өдрөөс 2023-05 -31-ний өдөр хүртэл зохион байгуулж, мэдээг өдөр болгон авч өссөн дүнгээр судалгаа гарган явцад хяналт тавьсан 05 сарын 29-ны өдрийн байдлаар нийт 1162 нэгж талбар Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдэж 9-суманд нөхөн бүрдүүлэлт дууссан байна.

2023-05-08-ны өдрөөс 2023-05-12-ны өдөр хүртэл Газрын даамлын үйл ажиллагаанд хяналт шалгалт, газрын төлбөрийн нэхэмжлэл үүсгэх, газрын кадастрын мэдээллийн санд нөхөн бүрдүүлэлт хийх ажлын удирдамжийн дагуу Баянхангай, Баянцогт суманд ажиллаж нөхөн бүрдүүлэлтийг бүрэн дуусгасаж Заамар суманд нийт 198 нэгж талбарыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн.

Газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг Газрын мониторингийн цахим системээр хүлээн авч баталгаажуулан ажиллаж байна. 2023.05.28-ны өдрийн байдлаар 157 мэдэгдэх хуудас хэвлэж өгснөөс 90 захиалгат хянан баталгааны тайланг цахимаар ирүүлсэн байна. Үүнээс: баталгаажуулсан төлөвтэй 67, Хянасан буцаасан 16, Илгээсэн 7 тайлан тус тус байна.

Аймгийн нутаг дэвсгэрт газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгаа хийж байгаа тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагуудад заавар зөвлөгөөг өгч шаардлага хангаагүй 32 тайланг буцаан засвар хийлгэн цахим системээр баталгаажуулан ажиллаж байна

Төв аймаг цагдаагийн газраас ирүүлсэн 5-н албан бичгийн дагуу лавлагааг гарган хүргүүлсэн.

Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэсийн албан бичгээр ирсэн түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар өргөдөл өгсөн 8 талбайд шүүлт хийж хариуг хүргүүлсэн.

Одонт хөтөл, Цэнгэлдэх, Эмнэлгийн уулзвар дээр хийх зогсоолын дэвсгэр байрзүйн зураглал хийж гүйцэтгэгч байгууллагад гаргаж өгсөн.

Зөвшөөрөлгүй барьсан Амбаар, Граш, Гадна фасад шинэчлэх орон сууц, шинээр хийх зогсоол, тохижилт, Баатруудын цэцэрлэгт хүрээлэн, дахин төлөвлөлтийн байршилүүд дээр дроноор зураг авч хэмжилт хийсэн.

Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн албан бичгийн дагуу 4 хэрэгт лавлагаа зураглал хүргүүлсэн.

Зуунмод суман дээр өргөдлийн дагуу 3 байршилд хяналтын хэмжилт хийж хариуг албан бичгээр хүргүүлсэн.

2023 оны сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 11896 нэгж талбарын 199260,7 га газрыг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд баталгаажуулж 1581 нэгж талбарын 2844,43 га газрыг олгож бүртгэж, аймгийн хэмжээнд газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт 13,26 хувьтай байна.

Засгийн газрын 20523 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 105 дугаар тогтоолоор 639 иргэнд 238,97 газрыг өмчлүүлээд байна.

Зуунмод сумын хэмжээнд зөвшөөрөлгүй барилга байгууламж барьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар чөлөөлөх мэдэгдлийг 20 байршилд нийт 120 амбаар, гарааш,

чингэлэг чөлөөлөхөөс 05 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 16 гарааш, 36 амбаарыг чөлөөлөөд байна.

ДӨРӨВ.ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Төрийн болон орон нутгийн өмчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэл, статистик мэдээ тайланд 28 байгууллагад засвар орж, алдааг залруулан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, нэгтгүүлсэн.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Улсын бүртгэлийн хэлтсээс актлуулахаар хүргүүлсэн тээврийн хэрэгслийг газар дээр нь үзэж, дүгнэлт гаргаж ирүүлэх хүсэлтийн дагуу тээврийн хэрэгслийг газар дээр үзэж дүгнэлт гарган хүргүүлсэн.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 14 дүгээр хуралдааны 08 дугаар тогтоолоор Лүн сумын ЭМТ-ийн балансаас Баянцогт сумын Эрүүл мэндийн төвийн балансад УАЗ Пургон маркийн автомашиныг шилжүүлж, цаашид ашиглалтын болон сэргээн босголтын зардал өндөртэй худалдахаар шийдвэрлэсэн 6 тээврийн хэрэгслийн дуудлагын худалдааг дахин зарлан 2023 оны 05 дугаар сарын 17, 19-ний өдрүүдэд зохион байгуулж ажилласан. Дуудлагын худалдаагаар аймгийн төсөвт 14,0 сая төгрөгийг төвлөрүүлэн ажиллаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 58 дугаар тогтоолоор худалдахаар шийдвэрлэсэн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй ширмэн цехийн барилгын дуудлагын худалдааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулахад Вектор гардан ХХК шалгарсан.

Аймгийн “Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын хүрээнд 2018 онд түрээсийн 12 өрх, 2019 онд 13, 2021 онд 1 өрх, нийт 26 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулснаар сарын графикт хугацааны төлөлтөд хяналт тавьж ажилласнаар 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 28.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дэх Зуунмод хотын төвлөрсөн хогийн цэгийн талбайд байрлах 357.1 мкв талбай бүхий “Аюултай хог хаягдлын агуулах”-ын эзэмшил, ашиглалт хамгаалалт, үйл ажиллагааг хариуцан ажиллахаар талууд харилцан тохиролцсоны дагуу “Технологи бридж” ХХК-д 3 жилийн хугацаатайгаар эзэмшихээр гэрээ байгуулах төслийн саналыг боловсруулан холбогдох удирдлагуудад хүргүүлсэн.

Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хичээлийн В байрны барилгыг Төмөр трейд ХХК-д түрээсийн гэрээгээр эзэмшүүлж байсныг гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж үзэн цуцлан, гөдлийн дагуу судлан үзэж, тайлбарыг Зуунмод сумын Засаг даргын албан бичгээр хүргүүлсэн.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХҮНС, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Мал төлөлт 2023 оны 05 дугаар сарын 31-ны байдлаар 2372086 толгой эх мал төллөхөөс нийт төллөх хээлтэгчийн 68.6 хувь буюу 1627262 толгой мал төллөж, 1555126 төл бойжиж, төл бойжилт 95.6 хувьтай байна.

Том малын зүй бус хорогдлоор нийт мал сүргийн 1.3 хувь буюу 67338 толгой мал хорогдоод байна.Үүнд: Адуу 3355, Үхэр 5442, Хонь 31477, Ямаа 27062, Тэмээ 2 толгой тус тус хорогдсон.

Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төслийн хүрээнд 520.0 сая төгрөгний өртөг бүхий Казакын цагаан толгойт хээлтүүлэгчийг нийт 19 сумын 45 малчинд 5 жилийн хугацаатай түрээсийн гэрээгээр олголоо.

Улсын төсвийн 150.0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар хийгдэж буй инженерийн хийцтэй 5 худаг гаргах ажлын гүйцэтгэлийг хүлээж авахаар ажлын хэсэг байгуулагдаж байна. Үхэр сүргийг ээмэгжүүлэн, бүртгэлжүүлэх ажлын хүрээнд Борнуур, Баянхангай сумын 1000 үхэр сүргийг ээмэгжүүлэх ажлыг хаврын технологит хугацаанд хийлээ.

Батсүмбэр, Баян-Өнжүүл, Алтанбулаг сумын зохион байгуулсан “Малчдын зөвлөгөөн”-д мал аж ахуйн салбарт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр, Засгийн газраас мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан зээл олголтын талаарх мэдээлэл болон бусад сэдвээр 500 гаруй малчин, мал бүхий иргэдэд мэдээлэл өглөө.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1023.0 мян.толгой мал, амьтан хамруулахаас 430.6 мян.толгой мал хамруулж 42.1 хувьтай, эм биобэдэмлийн татан авалт 79.5 хувьтай байна.

Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний угаалга, туулга, боловсруулалт, гуурын боловсруулалтын энэ оны төлөвлөгөөнд давхардсан 8488,2 мянган толгой мал хамрагдахад 1858,6 мян/ толгой мал хамрагдаж 21.8 хувьтай хэрэгжиж байна

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын төлөвлөлт МЭНС 2.0 –д 99.4 хувь, гүйцэтгэл 85.1 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд өнөөдрийн байдлаар хонины цэцэг өвчний голомт Баянцагаан суманд 3, Баянжаргалан суманд 1 үүсч, нийт 4 голомтоос Баянцагаан сумын 1 голомт тайван байдалд шилжсэн, 3 голомт хорио цээрийн дэглэмтэй байна.

5 сард хонины цэцэг өвчнөөр 53 хонь өвчилж, 20 мал устгаж, 33 малын шинж тэмдэг арилж, 15619 малыг дархлаажуулсан.

Эрдэнэ сумын Чулуут гэх газарт гоц халдварт бог малын мялзан өвчин оношлогдож хорио цээрийн дэглэм тогтоосон. Бог малын мялзан өвчнөөр хонь-85, ямаа-38 нийт 123 мал өвчилж 4 үхэж, 1 устгасан байна.

Аймгийн хэмжээнд нийтийн эзэмшлийн талбай 28,5 мян/м² хашаа хороо 304 өрхийн 217,8 мян/м² 6 Голомтын бүсийн 18,6 мян/м² 98 худаг уст цэгийн 9,4 мян/м², 7 Агуулах зоорь, түүхий эд агуулах цэгийн 3,8 мян/м² 46 устгалын цэгийн 42,1 мян/м², Бэлчээрийн 102,9 мян/м², нийт 423.4 мян/м² талбайд халваргүйтгэл хийж, 30,2 % -тай явагдаж байна.

5 дугаар сард 11719 мал, амьтан, 338.2 тн мах, махан бүтээгдэхүүн, 332 ширхэг арьс шир, 1061.4 тн сүү, сүүн бүтээгдэхүүн, 80 кг бяслаг, 100 литр айраг, 22962 кг ноолуур, 8002080 ширхэг өндөг, 299 ширхэг толгой, 227 ширхэг өлөн, 3020 кг өөх, 1383 кг дайвар бүтээгдэхүүнд 1611 мал эмнэлгийн гэрчилгээг олгож, 98 дуудлага үйлчилгээ үзүүллээ.

Лүн суман дахь Мал эмнэлгийн хяналтын цэг 4 ээлжээр 24 цагт малын шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэн явж байгаа нийт 362- тээврийн хэрэгсэл, амьд мал нийт-4667 толгой. Тэмээ-274 адуу-972, үхэр-157, хонь-3039, ямаа-225, Мах нийт-73226 кг тэмээ-3500кг, адуу мах-240 кг, үхэр мах-13220 кг, хонь мах-21010кг, ямаа мах-35256, Дайвар бүтээгдэхүүн-5050-кг, ноос-5050кг, ноолуур 131.1тн, үхрийн шир-400, нэхий-400, ямааны арьс-700 ширхэг арьсанд эрүүл ахуйн үзлэг хийн нийт-380 мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт шалгалт хийж ажиллалаа.

5 дугаар сарын байдлаар Үр тариа **49973** га, Улаанбуудай **47208** га, төмс **6600** га, хүнсний ногоо **810** га, таримал тэжээл **403** га, тосны ургамал **6498** га-д тус тус тариалаад байна. Аймгийн хэмжээгээр **64284** га-д тариалалт хийгдэж явц **47.6** хувьтай байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан батлуулсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих зээлийг аймгийн хэмжээнд **ХААН банк** 162 иргэн ААН-ээс 16 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт авснаас 8 тэрбум төгрөгийн зээлийг шийдвэрлэж олголоо.

Төрийн банк 1,3 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт хүлээн авсанаас 4 иргэнд 176 сая төгрөгийн зээл олгосон.

Өрхийн тариалалтыг дэмжих зорилгоор 80 хувийн хөнгөлттэй үнээр ХХААХҮЯ-с 478 987 275 төгрөгийн 13 төрлийн 170 га талбайд тариалах 21 тн хүнсний ногооны үрийг хүлээн авч 27 суманд олгосон.

Энэ жилийн тариалалтад нийт 9075 тн улаанбуудайны үр шаардлагатай байгаагаас 2022 оны ургацаас нөөцөлсөн 5900 тн үрийг ашигласан бөгөөд дутагдаж байгаа үрийг Хөдөө аж ахуйг дэмжих сангаас 30 хувийн урьдчилгаатай зээлээр олгох ажлыг зохион байгуулсан. Нийт хөдөө аж ахуйг дэмжих сангаас **66** аж ахуйн нэгж, иргэн, **3100** тн үр татан авч тариалалт хийж байна. Таримал тэжээлийн үрийг Милл хаус, Алейнка, Од групп, Пример агро ХХКомпаниуд тариаланчдад нийлүүлж байна.

ХХААХҮЯ-ны сайдын 2023 оны А/37 дугаар тушаалаар батлагдсан 900.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн дагуу олон нийтэд мэдээллийн хэрэгсэлээр зар хүргэж 4.5 тэрбум төгрөгийн 27 төсөл хүлээн авч 1-р дүгээр шатны шалгаруулалтаар 1.2 тэрбум төгрөгийн 7 төслийг шалгаруулан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ЖДҮГазарт хүргүүллээ.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ЖДҮГазар, Хөгжлийн шийдэл ТББ-ын БЭСТ төсөлтэй хамтран хэрэгжүүлж буй “5Х хоршоо хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд “Хоршооны бизнес төсөл боловсруулах”, “Гар урлалын салбар дахь оюуны өмчийн асуудлууд” сэдэвт сургалт 2, цахим хэлэлцүүлэг 2 удаа тус тус зохион байгуулж 23 хоршооны 42 гишүүнийг чадавхижууллаа.

Хоршоог хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлтэй 16 сумын 59 иргэн, аж ахуй нэгжийн мэдээллийг хянан Монгол банкны хариуцагчийн зээлийн мэдээллийн санд бүртгэлгүй болгох ажлыг зохион байгууллаа.

ЗУРГАА. СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:

Дэлхийн хэмжил зүйн өдөр нээлттэй хаалганы өдөрлөгийг ДСЦТС ХК, Жаргалант сумын ЗДТГ-тай хамтран 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр “Хэмжил дэлхийн хүнсний тогтолцоонд дэмжлэг үзүүлэх нь” уриатай зохион байгуулж, Стандартчилал техникийн зохицуулалт тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Хэмжил зүйн тухай хууль, Тохирлын үнэлгээ, баталгаажуулалт, Хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, Сорьцын хяналт, Сорилтын нэгдсэн лабораторын мэдээлэл сургалтад 35 худалдаа үйлчилгээ эрхлэгчдийг хамрууллаа. “Чанарыг эрхэмлэгч” шагналаар Жаргалант сумын З.Алтантүлхүүр эзэнтэй “Алтанцацрал хүнсний дэлгүүр”-ийг шалгаруулан урамшууллаа.

Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт, стандартын мэдээлэл лавлагааны хүрээнд: Тохирлын гэрчилгээ шинээр авах буюу сунгуулахаар 12 аж ахуйн нэгж, иргэний хүсэлт хүлээн авч Бүрэн, Борнуур, Баян-Өнжүүл, Жаргалант, Сүмбэр, Өндөрширээт суманд ажиллаж 60 худалдаа, үйлчилгээг тохирлын үнэлгээнд хамрууллаа.

Хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын хүрээнд: Массын хэмжлийн 3 төрлөөр Жаргалант, Баян. Цээл, Баян-өнжүүл, Бүрэн, Өндөрширээт, Зуунмод, Сүмбэр, Борнуур сумын худалдаа үйлчилгээ, нийтийн хоол үйлдвэрлэлийн 198 ш массын хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажууллаа.

Итгэмжлэгдсэн лабораторийн хүрээнд: Улаан буудай болон рапсын үр, гурилан бүтээгдэхүүн, хүнсний ногоо, Махан бүтээгдэхүүн, гүний ус, хоол, хүнсний ногоо, хэрчсэн гурил, аарц, гурилан 8 бүтээгдэхүүний 113 сорьцод 345 үзүүлэлтээр эрүүл ахуй хорио цээр, хими, нян судлалын шинжилгээ хийж ажиллалаа.

ДОЛОО.БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон сэргэлт Ногоон Төв аймаг” аяны нээлтийг хийж, мод үржүүлгийн газруудын тарьц суулгацын үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд 2870 иргэн Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж, 380 мянган мод бут, сөөг тариад байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 13-р хуралдааны 2-р тогтоолоор батлагдсан аймгийн байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэн, нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, “Нисдэг хулганы үүр” ХХК ажлыг гүйцэтгэн, Зуунмод сумын нийтийн эзэмшлийн 36 орон сууцны гадна талбайд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах зориулалт бүхий 20 ширхэг хогийн савыг байрлууллаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02, аймгийн Засаг даргын 01 дугаар албан даалгаварын хэрэгжүүлэх ажлын хүрээнд бүх нийтийн цэвэрлэгээнд аймгийн хэмжээнд нийт 163 төрийн болон аж ахуйн нэгж байгууллага, 4563 иргэн оролцож, 1367 тн хог хаягдал, 5017 сэг зэмийг цэвэрлэн, төвлөрсөн хогийн цэгт хүргүүллээ.

2023 онд аймгийн хэмжээнд 82 нүхэн жорлонг буулгахаар төлвөлсөн. Нийтийн эзэмшлийн талбайн нүхэн жорлонг буулгах ажлын хүрээнд Алтанбулаг сум 1, Баян сум 1, Баян-Өнжүүл сум 1, Баянхангай сум 1, Зуунмод сум 6, Лүн сум 1, Сүмбэр сум 2, Мэргэлэн сум 5, Эрдэнэ сум 1, нийт 9 сумын 19 нүхэн жорлонг буулгаад байна.

Дархан Улаанбаатар чиглэлийн зам хүлээн авах комисст 24-25-ны өдрүүдэд холбогдох мэргэжилтэнг томилон ажиллуулсан бөгөөд зам барилгын ажилд ашигласан кареруудын нөхөн сэргээлт хангалтгүй стандарт шаардлага хангаагүй тул нөхөн сэргээлт хийж дуустал хүлээн авахгүй байх шийдвэр гарсан.

Заамар суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 12 аж ахуйн нэгжүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж 4 аж ахуйн нэгжид албан шаардлага, 3 аж ахуйн нэгжид улсын байцаагчийн акт, 5 аж ахуйн нэгжид тогуулийн арга хэмжээ авч ажиллаа.

Аймгийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 40,000,000 сая төгрөгийн хөрөнгөөр Баян-Өнжүүл, Өндөрширээт сумын нутаг дэвсгэрт “Монгол тарвага сэргээн нутагшуулах ажил”-ын гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажил зохион байгуулагдаж шийдвэрийг гаргалаа. Тус ажилд 38,372,400 төгрөгөөр гүйцэтгэх санал ирүүлсэн Авралын Эрэлд ХХК-нь гүйцэтгэхээр шалгарсан.

НАЙМ. УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Агаарын дундаж температур: Нийт нутгаар -2.0°C ... $+2.4^{\circ}\text{C}$ байснаас Мөнгөнморьт суманд -2.0°C , Лүн, Өндөрширээт суманд $+2.4^{\circ}\text{C}$ байлаа. Олон жилийн дундажтай харьцуулахад Зуунмод суманд 0.3°C орчим, бусад сумдын нутгаар -1.4°C ... -3.2°C -ээр хүйтэн байв.

Хөрсний дундаж температур: Нийт нутгаар 0°C ... 7°C дулаан байснаас Зуунмод суманд 0°C , Лүн, Цээл суманд 7°C байлаа. Агаарт 30°C -ээс дулаан өдрийн тоо болон хөрсөнд 40°C -ээс дулаан өдрийн тоо ажиглагдаагүй.

Агаарын температурын үнэмлэхүй их утга: Нийт нутгаар $+18.9^{\circ}\text{C}$... $+25.3^{\circ}\text{C}$ хүрснээс Өндөрширээт суманд 30-ны өдөр $+25.3^{\circ}\text{C}$, хөрсний үнэмлэхүй их утга: $+35^{\circ}\text{C}$... $+49^{\circ}\text{C}$ ажиглагдсанаас Алтанбулаг, Баянцагаан суманд 30 ны өдөр $+49^{\circ}\text{C}$ хүрсэн байна.

Агаарын үнэмлэхүй бага утга: Нийт нутгаар -15.3°C ... -22.5°C хүрснээс Баян-Өнжүүл суманд 03-ны өдөр -22.5°C , хөрсөнд үнэмлэхүй бага утга: -17°C ... -27°C ажиглагдсанаас Баянчандмань суманд 03-ны өдөр -27°C хүрч хүйтэрсэн.

Тунадасны хувьд: Нийт нутгаар 0.8-13.5 мм тунадас орсон. Хамгийн их нь Зуунмод, Баянчандмань суманд 13.0-13.5 мм, хамгийн бага нь Бүрэн суманд 0.8 мм орсон нь олон жилийн дундажтай харьцуулахад: Зуунмод, Угтаал, Баянчандмань, Жаргалант, Борнуур, Заамар, Батсүмбэр, Цээл сумдын нутгаар ахиу, бусад сумдын нутгаар дунджаас бага тунадас орсон.

Салхины дундаж хурд: Нийт нутгаар 1.5-5.7 м/с байснаас Батсүмбэр суманд 1.5 м/с, Дэлгэрхаан суманд 5.7 м/с байв. Салхины их хурд: 10-24 м/с хүрснээс хамгийн их нь Зуунмод суманд 01-ний өдөр 24 м/с, Батсүмбэр суманд 01-ний өдөр 10 м/с хүрсэн байна. 10 м/с-ээс их хурдтай өдрийн тоо 1-24 өдөр байсны 24 өдөр нь Зуунмод суманд, Батсүмбэр суманд 1 өдөр ажиглагдсан. 15 м/с-ээс их хурдтай өдрийн тоо Зуунмод суманд 16 өдөр, Цээл, Аргалант суманд 1 өдөр Мөнгөнморьт, Баян-Өнжүүл, Борнуур, Батсүмбэр сумдад ажиглагдаагүй. Цастай өдөр 2-8, явган цасан шуургатай өдөр 1-3, явган шороон шуурга болон шороон шуургатай өдөр 1-9 өдөр, хүчтэй салхитай өдөр 1-8 өдөр тус тус ажиглагдсан байна.

Нарийвчилсан мэдээ, 1 хоногийн мэдээ, 5 ба 7 хоногийн мэдээ, сарын болон улирлын мэдээ, өнгөрсөн 1 болон 7, 10 хоног тутмын цаг агаарын тойм гаргаж И-мэйл-ээр дамжуулж, www.tuv.tsag-agaar.gov.mn сайт, TuvTsaguur page-д байршуулан, өдөр тутмын цаг агаарын мэдээг Зуунмод сумын ОНИМ-ийн ажилтанд И-мэйл ба “Дотоод удирдлагын систем”-ээр явуулах ажил тасралтгүй хийгдэж, байгууллагын урсдаг гэрлэн самбарт нарийвчилсан, хоногийн мэдээг өдөр бүр, нарийвчилсан анхааруулах мэдээ 20-ны өдөр, хоногийн анхааруулах мэдээ 18, 19-ний өдрүүдэд нийт 3 удаа, нарийвчилсан сэрэмжлүүлэг мэдээ 19-ний өдөр, хоногийн сэрэмжлүүлэг мэдээг 18-ны өдөр, нийт 2 удаа цасан шуурганы сэрэмжлүүлэг мэдээг гаргаж И-мэйл-ээр дамжуулж, www.tuv.tsag-agaar.gov.mn сайт, TuvTsaguur page-д байршуулан ард иргэдэд үйлчилсэн байна.

Агаарын чанарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч шинжилгээг хийн агаарын чанарыг тодорхойлж байна. Агаарын чанарын ажиглалтыг 05 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар азотын давхар исэл, хүхэрлэг хийн ажиглалтыг нийт 58 удаа хийсэн ба хүхэрлэг хийн 0.005 мг/м³ азотын давхар ислийн дундаж агууламж 0.006 мг/м³ үзүүлэлттэй байна. Өмнөх онд агаарын хэмжилтээ зогсоосон.

Гадаргын усны чанар: Усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 05 дугаар сард Туул-Лүн, Туул-Заамар, Шивэрт-Борнуур Хэрлэн-Мөнгөн морьт голуудын хяналт шинжилгээг хийхэд цахилгаан дамжуулах чанар нь Туул-Лүн 382 uS/cm, Туул-Заамар 320 uS/cm, Шивэрт-Борнуур 481 uS/cm Хэрлэн-Мөнгөн 87.4 uS/cm тус тус гарлаа.

Төв аймгийн нутаг дэвсгэрт 7-н ус судлалын харуул ажиллаж байгаагаас 2023 оны 05 дугаар сарын 21-ний байдлаар усны түвшин: Хэрлэн гол Хэрлэн-Хонгон 140 см, Хэрлэн-Мөнгөнморьт 93 см, Туул гол Туул-Алтанбулаг харуулд 540 см, Туул-Лүн харуулд 140 см, Туул-Заамар харуулд-157 см, Сөгнөгөр голын дагуух Сөгнөгөр-Сөгнөгөр харуул 193 см, Шивэрт голын дагуух Шивэрт-Борнуур харуул 169 см тус тус байсан ба өмнөх оныхтой харьцуулахад усны түвшин Хэрлэн голын дагуух Хэрлэн-Хонгон харуул 11 см бага, Хэрлэн-Мөнгөнморьт харуул 18 см их, Туул голын дагуух Туул- Алтанбулаг харуул, Туул-Лүн харуул, Туул-Заамар харуулууд 9-14 см их, Сөгнөгөр голын дагуух Сөгнөгөр-Сөгнөгөр харуул 3 см их, Шивэрт голын дагуух Шивэрт-Борнуур харуул 34 см их байна.

ДОЛОО. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 05-р сарын 15-ны өдрийн 53 дугаар зарлигаар Төв аймгийн хэмжээнд “Эхийн алдар”-I зэргийн одонгоор 33, “Эхийн алдар”-II зэргийн одонгоор 271, нийт 304 эх шагнагдлаа. “Эхийн алдар” одон гардуулах ёслолын ажиллагааг 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Монгол Туургатан театрт зохион байгуулж, УИХ-ын гишүүн Ж.Батжаргал, УИХ-ын гишүүн Ц.Туваан, аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар нар одонг гардуулан өглөө.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хамгаалах хүрээнд Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлыг зохион байгуулж 2023 онд 1-р ангид элсэн суралцах 13 хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулах, холбон зуучлах, хүүхэд тус бүрд “Хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө”-г сургууль тус бүр боловсруулан, боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулахыг чиглэл болголоо.

3. Монгол Улсын урт хугацааны “Алсын хараа 2050” хөгжлийн бодлогын хүрээнд бүх нийтийн соёлын боловсрол, соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой “СОЁЛЫН СЭРГЭЛТ” аяныг 05-р сарын 08-нд Төв аймгаас эхлүүллээ. “СОЁЛЫН СЭРГЭЛТ” аяны хүрээнд Чингис хаан Үндэсний музей, Аймгийн Соёл урлагийн газартай хамтран Лүн, Баянхангай, Заамар, Угтаалцайдам, Цээл, Сүмбэр, Жаргалант, Борнуур, Баянчандмань, Алтанбулаг, Аргалант, Өндөрширээт, Эрдэнэсант, Баянцогт зэрэг 14 суманд 05-р сарын 11-25 өдрүүдэд ажиллаж 7188 иргэнд хүрч үйлчиллээ.

4. Аймгийн Засаг дарга бөгөөд хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүний нэрэмжит “Амжилтын од” медалиар сурлага хөдөлмөр, урлаг спортын амжилтаараа тив дэлхийд болон улсдаа өндөр амжилт гарган манлайлсан 90 сурагчийг шагнаж, урамшуулан алдаршууллаа.

5. Инчөөны ЭМ салбар гадаад харилцаа тогтоосон ХНХЯ-ы хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах талаар сайн туршлагыг 21 аймаг, 9 дүүргийн салбар комиссын гишүүдэд танилцуулав.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн 29 өргөдөл, гомдол, 15 албан бичгийг хүлээн авч 25 өргөдөл, 13 албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэн, өргөдөл, албан бичгийн дагуу 16 ААН, байгууллагад НДШимтгэл дутуу тооцсон зөрчилд 2,9 сая төгрөгийн УБАкт тогтоож 100 хувь барагдууллаа.

Малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох сумд дахь орон тооны бус байнгын зөвлөлийн 60 тогтоол, шинээр тогтоогдсон 66 тэтгэврийн хувийн хэрэгт хяналт шалгалт хийж зөвлөмж хүргүүллээ.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр баталсан нэгдсэн удирдамжийн дагуу Нийгмийн халамжийн тухай хуулиар тэтгэвэр тогтоолгон авч байгаад нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх хангасан 2105 иргэний тэтгэврийн олголтыг шалгаж, 50 иргэнд нийгмийн халамжийн сан болон нийгмийн даатгалын сангаас олгох тахир дутуугийн тэтгэврийг давхардуулж 20,422,127 (Хорин сая дөрвөн зуун хорин хоёр мянга нэг зуун хорин долоон) төгрөгийн тэтгэвэр илүү олгосон зөрчлийг илрүүлж, 14 иргэний 5,734,090 (таван сая долоон зуун гучин дөрвөн мянга ерэн) төгрөгийг буцаан залрууллаа. Үлдсэн 38 иргэнд илүү олгосон 13,848,037 (арван гурван сая найман зуун дөчин найман мянга гучин долоон) төгрөгийн тэтгэврийг халамжийн санд буцаан төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоож шийдвэрлэв.

Хэлтсийн хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь ААН, Байгууллагаас ирсэн албан бичгийн дагуу хяналт шалгалт хийж 1 ажил олгогчид 2,6 сая төгрөгийн УБАкт тогтоож, зөрчлийн тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар буруутай албан тушаалтанд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж шийтгэврийн хуудсаар 500000 төгрөгийн торгууль оногдуулж, зөрчлийн хувийн хэргийг прокурорын газарт хүргүүллээ.

Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК-ын хурлыг 4 удаа 18 цаг хуралдаж, нийт 174 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 15 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 156 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 9 иргэний актыг цуцаллаа.

Нийгмийн даатгалын сангаас хамтран ажиллах гэрээний дагуу Хаан, Төрийн банкаар 17860 тэтгэвэр авагчдад 8,6 тэрбум төгрөгийн тэтгэврийг олголоо.

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

Нийгмийн халамжийн чиглэлээр:

1.2023 оны 5-р сарын байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэр 1888 иргэнд 2597,5 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмж 1191 иргэнд 521,3 сая төгрөг, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж 11 иргэнд 13,2 сая төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тусламж 1204 иргэнд 384,3 сая төгрөг, алдарт эхийн одонтой 9476 иргэнд 1221,5 сая төгрөг, ахмад настны хөнгөлөлт тусламжид 3396 ахмад настанд 205,1 сая төгрөг, Насны хишиг 5963 иргэнд 476,7 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламжид 587 иргэнд 621,4 сая төгрөг, жирэмсэн 990 эхэд 117,4 сая төгрөгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсны тэтгэмж 4222 иргэнд 882,7 сая төгрөг, 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж 311 иргэнд 166,9 сая төгрөг, ихэр хүүхдийн тэтгэмж 11 иргэнд 22 сая төгрөг, Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 32885 хүүхдэд 1645,8 сая төгрөг тус тус олголоо.

2.Шинээр төрсөн 112 хүүхдийн мэдээллийг и-халамж системээр бүртгэж, Хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой журам, чиглэлийн талаар 80 гаруй иргэнд мэдээлэл өглөө.

3.Нийгмийн хөгжлийн чиглэлээр: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 05 дугаар сард 14 хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон байнгын асаргааг сунгаж, 2 хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон байнгын асаргааг шинээр тогтоосон. Ерөнхий боловсролын сургуульд хамрагддаггүй 3 хүүхдийг хувилбарт сургалтад хамруулах, 3 настай 1 хүүхдийг цэцэрлэгт хамруулах талаар холбогдох байгууллагад чиглэл өгч ажиллалаа.

4.Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн чиглэлээр: Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай 358 өрхийн 915 иргэн, 996 хүүхдэд 22,8 сая төгрөгийн 10-н нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн олгож хүнс тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийллээ. Мөн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг Зуунмод сумын 23 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө өглөө.

5.Судалгааны мэдээллээ зөрүүтэй өгсөн 7 өрхийн мэдээллийг мэдээллийн эх сурвалжтай тулган, баталгаажуулж оноог бодууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

1.Хөдөлмөр эрхлэлтийн төсөл арга хэмжээний танилцуулга, Ejob платформ, Ehalamj системийн талаар 300 гаруй иргэдэд мэдээлэл хүргэн ажиллалаа.

2.Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн Ejob программд 5-р сарын байдлаар 142 ажил олгогч, 251 иргэн ажил хайгчаар бүртгэгдлээ.

3.Шинээр бий болсон ажлын байр 97-г бүртгэн мэдээллээ. Үүнээс түр 57, улирлын 13, байнгын шинэ ажлын байр 27 бүртгэгдлээ. /нийт 253 ШАБ 156 үүнээс: байнгын 173, улирлын 15, түр 65/

4.Нийт 20 ажил олгогчийн 265 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг хүлээн авч 96 /164 иргэн/ иргэнийг тохирох ажлын байранд зуучиллаа.

5.Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдах хүсэлтээ ирүүлсэн 22 иргэний бүртгэлд хамрагдсан тухай тодорхойлолтыг Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүллээ.

6.Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрийн талаар: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл, хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 24 сумын 112 иргэний төслийг хүлээн авч аймгийн болон сумын ажлын хэсгээр хамтран хэлэлцүүлж 72 санхүүжүүлэхээр шийдвэрлэлээ. Үүнд: Ахмад настан олгох санхүүгийн дэмжлэгийн хүрээнд 40 төслийг хэлэлцэж 26 иргэнд санхүүжилт олгох, Иргэнд олгох санхүүгийн дэмжлэгийн хүрээнд 42 төслийг хэлэлцэж 30 иргэнд санхүүжилт олгох, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох санхүүгийн дэмжлэгийн хүрээнд 30 төслийг хэлэлцэж 16 иргэнд санхүүжилт олгохоор тус тус шийдвэрлээд байна.

7.Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн талаар:Тайлант хугацаанд 152 иргэний 62563.6 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг ХЭДСанд төвлөрүүлж, өссөн дүнгээр 339 иргэний 285614.5 мянган төгрөг төвлөрүүллээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн ажлын байрны төлбөрт өссөн дүнгээр Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК-аас 4 иргэний 46140.0, Илт гоулд ХХК-с 4 иргэний 79414.9, Уулс заамар ХХК-с 4 иргэний 11000.0 төгрөг нийт 12 иргэний 65054.% мянган төгрөгийг ХЭДСанд төвлөрүүлэн ажиллалаа.

8.Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний талаар:Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээг МУШМАкадемийн дэргэдэх Сонор эдүкейшн сургалтын төвтэй хамтранАлтанбулаг,Баянчандмань, Борнуур, Бүрэн, Угтаалцайдам, Цээл, Заамар сумдын 531 төгсөх ангийн суралцагчид, ажилгүй 212 иргэнийг ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулж, ХЭДСангаас4,4 сая төгрөгийг зарцууллаа.

9.Байгууллагын үйлчилгээг танилцуулах, ажил олгогч, ажилгүй иргэдийн уулзалт арга хэмжээг 2023 оны 05 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд Заамар сумын төв болон Хайлааст багт зохион байгуулж ажиллалаа. Өдөрлөгөөр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэргэжил

сонголт бүлгийн сургалтад 8-11 дүгээр ангийн 131 сурагч, ажилгүй болон ажил олоход хүндрэлтэй зорилтод өрхийн 40 иргэн хамрагдсанаас эрэгтэй 16, эмэгтэй 24 иргэнийг хамруулж зөвлөгөө мэдээлэл өгч 8 иргэнийг ажлын байранд зуучиллаа.

10.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах 6 иргэнтэй гэрээ байгуулж, 2019-2022 онд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 4 иргэний төсөл, үйл ажиллагаатай танилцлаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр

1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 07/001 дугаар удирдамжийн дагуу Зуунмод суманд шинээр баригдаж байгаа барилгууд болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын захиалгаар Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилгыг барьж буй Баян эрхт гүн ХХК, БЗОСК ОНӨААТҮГазрын захиалсан 160 хүүхдийн дотуур байр барьж буй Баян дөрвөлж ХХК, 42 айлын орон сууц барьж буй Төв Цогт-Өлзийт ХХК, 8 давхар 63 айлын орон сууц барьж буй Нью прожект констракшн ХХК-иудад урьдчилан сэргийлэх шалгалт хийлээ.Шалгалтаар ХАБЭА-н тухайн жилийн төлөвлөгөө, төсөв батлаагүй, ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийгээгүй, сургалтын төлөвлөгөө батлаагүй, сургалт зохион байгуулаагүй, ХАБЭА-н дотоод хяналт шалгалт хийдэггүй зөрчлүүд илэрсэн. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар 4 аж ахуйн нэгж тус бүрд албан шаардлага хүргүүллээ.

2.Салбарын улсын ерөнхий байцаагчийн 07/13 дугаар удирдамжийн хүрээнд Заамар суман дахь МСҮТөвд төлөвлөгөөт шалгалт болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн улсын үзлэг, Монголросцветмет ТӨҮГазрын харьяа “Шижир алт” алтны үйлдвэрт төлөвлөгөөт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар зөвлөгөө мэдээллийг хүргүүллээ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД:

1.Аймгийн хэмжээнд 2023 оны 4 дүгээр сарын байдлаар 304 эх төрж өнгөрсөн оны мөн үеэс 125 тохиолдлоор өссөн ба 306 нярай бүртгэгдсэн. Жирэмсний хяналтад нийт 691 эх байна. 385 жирэмсэн эхийг шинээр хяналтад авч, эхний 3 сартай хяналтад 93.77% хамрагдсан. Нийт 118947 хүнд үзлэг хийсэн ба үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 33889, амбулаторийн үзлэг 71316, идэвхтэй хяналтын үзлэг 8303 хүнд хийсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 5182 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Эмнэлэгт 5899 хүн эмчлэгдэн нийт 42969 ор хоног ашигласан. Дундаж ор хоног 7.3 байна. Аймгийн хэмжээнд нийт 164 нас баралт бүртгэгдсэн, эмнэлгийн нас баралт 20.73%, хорт хавдрын нас баралт 44 тохиолдол буюу 26.83%, гаднын шалтгаант нас баралт 32 буюу 19.51%-ийг эзэлж байна.

2.Монгол Улсын Засгийн газар, Монголын Сувилагчдын Нийгэмлэг, УИХурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн ажлын алба санаачлан Төв аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд, аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурал, аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГазрын дэмжлэгтэйгээр“Сувилахуй ба эрх зүй”, “Сувилагч, тусгай мэргэжилтнээ сонсоё” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт төр, хувийн хэвшлийн 36 Эрүүл мэндийн байгууллагын 300-аад сувилагч, тусгай мэргэжилтүүдийг оролцуулан, эмнэлгийн мэргэжилтний хууль эрх зүй, харилцааны эрх зүйн чиглэлээр мэдлэг, хандлагыг дээшлүүллээ.Тус арга хэмжээний хүрээнд Хавдар судлалын Үндэсний төвтэй хамтран хавдрын урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулан, аймгийн Эрүүл мэндийн салбарын нийт 132 эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг үзлэгт хамруулан, онош тодруулах шаардлагатай 29 хүнийг дээд шатлалруу илгээж, хяналт, эмчилгээнд хамрууллаа.

3.Аймгийн Эрүүл мэндийн салбарын хэмжээнд сувилагч, тусгай мэргэжилтний дунд жил бүр зохион байгуулдаг “Онол практикийн бага хурал”-ыг 2 үе шаттай зохион байгуулж, 1-3 байр, Уран илтгэгч шалгаруулан, өргөмжлөл, цалингийн 20-30%-р шагнаж урамшууллаа.

4.Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Бидний сувилагчид, Бидний сувилагч” улсын хүндэтгэлийн арга хэмжээ, Сувилахуйн амьдрал төвөөс улсын хэмжээнд зохион байгуулсан “Алтан дэнлүү” ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд аймгийн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 65 сувилагч, тусгай мэргэжилтнүүд оролцож, АНЭ-ийн 2 сувилагч “Шилдэг сувилагч” шагнал хүртлээ.

5.Аймгийн Эрүүл мэндийн газраас магадлан итгэмжлэлд хамрагдсан Нэгдсэн эмнэлэг, Замтын булаг, Арга билэг сувилалуудын Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын төлөвлөгөөг хянан, зөвлөн тусалж ажиллалаа.

6.2023 оны Эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тендерт шалгарсан 15 эм ханган нийлүүлэх компанитай гэрээ байгуулан, шалгараагүй 10 багцыг дахин нээлттэй тендер зарлахаар бэлтгэсэн.

7.Эрүүл мэндийн хөгжлийн төв, аймгийн Эрүүл мэндийн газар хамтран “Шинэчилсэн хүүхдийн өвчний цогц менежмент” сэдэвт 5 хоногийн танхимын сургалт зохион байгуулж, аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрх, сумын Эрүүл мэндийн төвийн нийт 27 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан, НҮБ-ын ХАС-ын санхүүжилтээр олгогдож байгаа ХӨЦМ-ийн эмнэлзүйн ном, 5 төрлийн ханын хүснэгтэн товхимлыг эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан олгосон. Сургалтын үр дүнд оролцогчдын мэдлэг хандлага 86.6%-д хүрч, 46.1%-р өссөн үр дүнтэй байна.

8.Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг хамтран “Эрүүл эхээс Эрүүл хүүхэд” аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр “Эх, хүүхдийн тусламж үйлчилгээнд чанарын ахиц гаргая” зөвлөгөөн зохион байгуулж, Эрүүл мэндийн салбарын удирдлагууд, эх барих, эмэгтэйчүүдийн Зөвлөх эмч, Төрөх тасгийн эрхлэгч болон бусад төрөлжсөн мэргэжлийн их эмч нар, 26 сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн эх баригч нар нийт 40 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан, чадавхжууллаа.

9.БНСУ-ын Инчеон хотын 10 гаруй хувийн эмнэлгийн эмч нар ирж АНЭ-ийн үйл ажиллагаатай танилцан, харилцан мэдээлэл, туршлага солилцлоо.

10.Аймгийн хэмжээнд 6 сумын ЭМТ-ийн даргын сул ажлын байр зарлагдаж, Угтаалцайдам сумын ЭМТ-ийн даргын ажлын байр нөхөгдсөн.

11.Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дахь заалтаар 4 хүнд 18,6 сая, 29.2 дахь заалтаар 3 хүнд 52,1 сая төгрөгийн нэг удаагийн мөнгөн урамшуулал тус тус олголоо.

12.Эрүүл мэндийн салбарын хэмжээнд “**Хамтдаа зөвлөлдөн шийдье**” зөвлөн туслах үйл ажиллагааг ЭМГ, ЭМДХ хамтран зохион байгуулж, 15 сумын Эрүүл мэндийн төвийг хамрууллаа.

Халдварын хяналт, сэргийлэлтийн чиглэлээр:

1.Ковид-19 цар тахлын эерэг тохиолдлын нөхцөл байдлын мэдээг өдөр бүр нэгтгэн ХӨСҮТ, ЭМЯ, орон нутгийн удирдлагуудад хүргэж байна. 05 дугаар сард 39 эерэг тохиолдол бүртгэгдэн, эмнэлэгт 12, гэрийн хяналтад 27 хүнийг авч, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүллээ.

2.Салхин цэцэг, энтеровирус, гар хөл амны өвчин, улаан эсэргэнэ зэрэгхалдварт өвчний сэжигтэй тохиолдол 81 бүртгэгдэн, тандалт судалгаа хийж, эмчилгээнд хамрууллаа.

3.Аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрх, сумын Эрүүл мэндийн төвүүдийн угаалгын газрын үйл ажиллагаанд үнэлгээ хийж,ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны албанд хүргүүлсэн. Үнэлгээний дундаж 84%-тай байна.

4.Заамар суманд зохион байгуулагдсан гамшгаас хамгаалах Команд штабын сургуулилтад ЭМГ-ын Зооноз халдварт өвчин тандалт сэргийлэлтийн албаны Тархвар судлагч их эмч, Тархвар судлагч бага эмч нар 6 байгууллагын 66 бие бүрэлдэхүүн, 5 сумын 60 албан хаагчид Зоонозын халдварт өвчний тухай ойлголт, хариу арга хэмжээ сэдвээр сургалт зохион байгуулсан.

5.Зуунмод сумын Дэгдээхэй, Унагалдайн андууд цэцэрлэгийн 210 мкв талбайд халдварт өвчний дараах эцсийн халдваргүйжүүлэлт хийж, зөвлөмж хүргүүлсэн.

6.6 сумын Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвүүдэд халдварын хяналт, сэргийлэлтийн чиглэлээр хяналт шалгалт хийж, хими нян судлалын 25 сорьц авч, орчны эрүүл мэндийн лабораторт шинжилгээ хийж, дүгнэлт гаргалаа.

Эрүүл мэндийн чиглэлээр зохион байгуулагдсан 5 удаагийн мэдээлэл, сургалт сурталчилгаанд нийт 32 байгууллагын 320 гаруй хүн хамрагдлаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

1.ЭМДЕГ-тай гэрээт Төв аймгийн 75 Эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн 2 тэрбум төгрөгний 22476 гүйцэтгэлд хяналт хийж, 580 гүйцэтгэлийн 182 сая төгрөгийн зөрчил илрүүлэн, зөвлөмж хүргүүлсэн.

2.Гэрээт 12 сумын Эрүүл мэндийн төвийн 130 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах нь” сэдэвт ажлын байрны сургалт зохион байгуулж, ЭМДҮЗ-ийн 2022 оны “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” тогтоолууд, ЭМДЕГ-н даргын А/139 дугаар тушаалыг тус тус танилцуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ажиллалаа.

3.“Хамтдаа зөвлөлдөн шийдье” зөвлөн туслах үйл ажиллагааны хүрээнд Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

4.Зуунмод сумын 6 баг, 8 зах худалдааны төвүүдээр 350 гаруй иргэдэд Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, ЭМД-ын Үндэсний зөвлөлийн тогтоол, шийдвэрийг сурталчлан, заавар зөвлөмж өгч, ажилласан. ЭМД-ын ач холбогдол, хөнгөлөлттэй тусламж үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгааг иргэдээс авч дүгнэхэд сэтгэл ханамж 89%-тай үнэлэгдсэн байна.

БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭНД:

1.Сургуулийн менежментийг сайжруулах Боловсролын Ерөнхий газрын зөвлөн туслах "Сургуулийн менежмент" 2-р ээлжийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургууль, Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуульд амжилттай зохион байгуулагдаж, сургуулийн менежментийн 1-р ээлжийн үйл ажиллагааны дагуу төлөвлөсөн ажлуудын үүрэг даалгаврын биелэлттэй танилцан сургуулийн зорилго төлөвлөлтийг сайжруулах, стратеги төлөвлөгөө боловсруулах судалгаа, төсөл бэлтгэлээ.

2.Сургуулийн өмнөх боловсролын ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллаж буй багш нарыг чадавхжуулах сургалтын орон нутаг дахь 2-р үе шат амжилттай зохион байгуулагдаж, Сургалтад аймгийн СӨБ-ийн 41 байгууллагын 76 багш хамрагдаж арга зүйн зөвлөгөө мэдээлэл авлаа.

3.Монгол Улсад Азийн физикийн олимпиад зохион байгуулагдахтай холбогдуулан "Мэдлэгийн Квантаа түгээе" уриатай багш, сурагчийн танин мэдэхүйн өдөрлөгийн үйл ажиллагаа 2023 оны 05-р сарын 05-ны өдрөөс 07-ны өдрүүдэд Хүмүүн цогцолбор сургуультай хамтран амжилттай зохион байгуулагдлаа. Мөн элсэлтийн ерөнхий шалгалт өгөх 67 сурагчид шалгалтад бэлтгэх онолын болон бодлогын давтлага сургалтыг хийлээ

4.Ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах ажлын хэсэг БШУГ-ын даргын 2023 оны 5-р сарын 09-ний өдрийн А/32 дугаар тушаалаар 30 сургуулийн захирал, БШУГ-ын мэргэжилтэн, сургалтын менежерүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулагдан сургуулийн үнэлгээний багийг чиглэл, зөвлөмжөөр ханган хамтран ажиллаж амжилттай зохион байгууллаа.

5.Улсын төрөлжсөн олимпиадын III даваанд Төв аймгийн Батсүмбэр сумын ЕБС-ийн 12а ангийн сурагч Баяндалайн Лхагвачимэг Улсын монгол хэл, бичгийн 52 дугаар олимпиадаас Мөнгө, монгол бичгийн 17 дугаар олимпиадаас Хүрэл медаль хүртэн, бахдам амжилт гаргаж УЛСЫН ОЛИМПИАДЫН ХОС МЕДАЛЬТАН боллоо.Мөн Техник технологийн 24-р олимпиадад амжилттай оролцож, Дизайн технологийн эмэгтэй багшийн төрөлд Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн багш Л.Хонгорзул 2-р байр мөнгөн медаль, дизайн технологийн эмэгтэй сурагч төрөлд "Хүмүүн" цогцолбор сургуулийн сурагч Х.Намуун шагналт 5-р байр, нисэх загварын төрөлд "Хүмүүн" цогцолбор сургуулийн сурагч Х.Бат-Эрдэнэ шагналт 4-р байр, авто загварын төрөлд Зуунмод 4-р сургуулийн сурагч Н.Ууганбаяр шагналт 5-р байранд тус тус орсон амжилтуудыг гаргалаа.

6.ЭЕШ-д бүртгүүлсэн шалгуулагчдаас ЭЕШ өгөх эрх олгох "Монгол хэл бичгийн шалгалт"-д Алтанбулаг сумын ЕБС-ийн 12а ангийн сурагч Б.Баярцэцэг, Хүмүүн цогцолбор сургуулийн 12б ангийн сурагч Н.Даваадулам нар 800 оноо авлаа.

7.ЕБ-ын сургуулиудын ЭЕШ-ын явцын үнэлгээ хийж, бэлтгэл ажлыг эрчимжүүлэн, багш сурагчдыг урамшуулан дэмжих зорилгоор УИХ-ын гишүүн Ж.Батжаргалын нэрэмжит "Амжилтын хөтөч" ЭЕШ-ын сорилгыг зохион байгууллаа.

Судлагдахуун	Сургууль	Сурагчийн нэр	Сургууль	Бэлдсэн сурагчид нь сорилд тэргүүлсэн Багшийн нэр
МХБУЗ	Алтанбулаг	Г.Мөнхжин	Алтанбулаг	Л.Алтансоёмбо
Англи хэл	ХЦС	Г.Түмэн-Амгалан	Хүмүүн ЦС	Ц.Наранчимэг
Орос хэл	ХЦС	Н.Маралгоо	Баянчандмань	Б.Туяацэцэг
Математик	ХЦС	Э.Дөлгөөн	Заамар	Б.Базарваань
Физик	Батсүмбэр	Д. Балжинням	Хүмүүн ЦС	Р. Эрдэнэцэцэг
Хими	Хүмүүн	Д.Цэвэлмаа	Хүмүүн	Б. Бадамгарав
Биологи	Хүмүүн	Эба.Номин-эрдэнэ	Хүмүүн	Г.Улаанаа
Газарзүй	Заамар 1	Б. Азжаргал	Хүмүүн ЦС	Н. Нанзайбаатар
Түүх	Алтанбулаг	Г.Түвшинбаяр	Алтанбулаг	С.Балдангомбо
НУ	Зуунмод-4	Хандмаа	Хүмүүн	Б.Жавзандулам

8.БШУГ-ын мэргэжилтнүүд Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан “Боловсролын менежмент, технологи, манлайлал” и-сургалтад хамрагдаж амжилттай суралцаж БАТЛАМЖ авсан.

9.Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан сургалтын байгууллагын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах “Мэргэшсэн шинжээч багш” сургалтад хамрагдаж үнэмлэх, сертификат авсан.2023 оны 05 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд Баянжаргалан сумын ЕБС, суралцагчдын дотуур байр, СӨБ-ын байгууллагаар төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн.

10.2023 оны 05 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд гүйцэтгэлийн үнэлгээнд Зуунмод сумын ХЦС, ЕБ-ын IV,V-р сургуульд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж шалгалтын танилцуулгыг салбарын хяналтын газарт илгээсэн.

11.Боловсролын Ерөнхий газар болон "Жайка" ОУБ-ын хамтран хэрэгжүүлж буй "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах нь" II шатны төслийн баг Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын лаборатори "Хүмүүн" цогцолбор сургууль, Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургууль дээр зөвлөн тусалж, мониторинг хийлээ.Мөн Батсүмбэр, Зуунмод сумын ЕБСургуулиудын “Дэмжлэгийн баг”-ийн гишүүд, багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах арга зүй олгох нь” сэдэвт 2 дахь удаагийн сургалтыг амжилттай зохион байгуулан 4 сургуулийн нийт 35 багш, ажилчид хамрагдлаа.

12.Төв аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын 2 дахь удаагийн "Кейс хэлэлцүүлэг" Эрдэнэ суманд зохион байгуулагдлаа. Кейс хэлэлцүүлэгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын чиглэлээр хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгсөн. Хэлэлцүүлэгт хөндлөнгийн ажиглагчаар "Жайка" ОУБ-ын "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах нь" II шатны төслийн менежер Иши Сан, төслийн зохицуулагч Х.Ганбаатар нар оролцлоо.

13.Тусгай хэрэгцээт боловсрол-Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл /ЕБС/ Төв аймгийн Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн 2023-2024 оны хичээлийн жилийн бэлтгэлийн хурал 05 сарын 23-нд БШУГ-т зохион байгуулагдав. Зөвлөлийн хурлаар аймгийн 7 сумын боловсрол болон хөгжлийн үйлчилгээнд хамрагддаггүй хөгжлийн бэрхшээлтэй 13 хүүхдийг оролцуулж, боловсролын үйлчилгээнд хамруулах, холбон зуучлах шийдвэрийг зөвлөлөөс гаргалаа. Хуралд ерөнхий боловсролын 6 сургуулийн удирдлагууд, нийгмийн ажилтан, багш нар, эцэг эх асран хамгаалагч нарын төлөөлөл цахимаар, Зуунмод сумын сургуулийн төлөөллүүд танхимаар хамрагдан хуралд оролцсон 13 хүүхэд 2023-2024 оны хичээлийн жилд шинээр 1-р ангид элсэн суралцахаар боллоо.

14.“Гамшиг онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал”-сургалт ХНХЯ, НҮБ-ын Хүүхдийн сангаас зохион байгуулж буй “Гамшиг онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал” сэдэвт 2 өдрийн сургалтад аймгийн ОБГ, ЭМГ, БШУГ, ГБХЗХГ, ЦГ-ийн төлөөллүүд Өмнөговь аймагт танхимаар хамрагдлаа.

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ХҮРЭЭНД:

1.“Соёлын сэргэлт-2023” аяны сургагч багш бэлтгэх сургалт зохион байгууллаа.Соёлын боловсролын үйл ажиллагааг орон нутагт түгээн дэлгэрүүлэхэд Театр, Музей, Номын сан, сумдын ЕБС-ийн багш нарын төлөөллийг мэргэжил ур чадварыг сайжруулах зорилго бүхий энэхүү сургалтад Төв аймгийн сумдын Албан бус насан туршийн боловсролын төвийн багш, МТТеатр, Аймгийн музей, Нийтийн номын сангийн нийт 32 албан хаагч хамрагдлаа. Тус сургалтад Чингис хаан Үндэсний музейн захирал, Академич С.Чулуун, Аймгийн Соёл, урлагийн газрын дарга Б.Тунгалаг, Албан бус насан туршийн боловсролын төвийн захирал Т.Идэр нар оролцож, Чингис хаан Үндэсний музейн захирал, Академич С.Чулуун “Чингис хаан Үндэсний музей тухай”, Соёлын яамны Соёлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч доктор Ш.Оюундэлгэрэх “Хүн амын соёлын боловсролыг дээшлүүлэхэд соёлын үйлчилгээг чиглүүлэх нь”, Соёлын яамны монгол хэл, бичгийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн доктор Т.Пүрэвсүрэн “Эх хэлний боловсрол Хос бичигтэн, Толь бичиг ашиглах, Хүүхдийн үгийн сан”, Чингис хаан музейн Боловсрол, олон нийтийн харилцаа, маркетингийн хэлтсийн дарга Д.Эрдмаа “Музейн боловсролын хөтөлбөрийн арга зүй”, Их засаг лицей сургуулийн хөгжмийн багш Ц.Ууганцэцэг “Соёлын өвд тулгуурласан интеграц хичээл”, Монголын сургуулиас гадуурх сургалтын Санрайс Холбооны сургагч багш нар “Театрын сурган

хүмүүжүүлэх арга зүйн сэргээх дасгал, тоглоом, түүнийг сургалтад хэрэглэх" сэдвээр тус тус илтгэл тавьж, дадлага ажил гүйцэтгэв.

2.Аймгийн мэргэжлийн урлагийн байгууллага Монгол туургатан театрын уран бүтээлчидээс Олон улсын болон улсын чанартай мэргэжлийн уралдаанаас олон сайхан шагналын эзэд төрлөө.Энэхүү талархалтай ажлын хүрээнд эрхэм уран бүтээлчдэд аймгийн Соёл, урлагийн газраас хүндэтгэл үзүүлэх "Өглөөний цай" арга хэмжээг 05 дугаар сард зохион байгууллаа.

3.Баянцагаан суманд "ХХ зууны манлай хурд" музей 05 дугаар сарын 28-нд байгуулагдаж нээлтийн үйл ажиллагаанд аймгийн СУГ хүндэтгэл үзүүлж оролцлоо.

МОНГОЛ ТУУРГАТАН ТЕАТРЫН АЖЛЫН ХҮРЭЭНД:

1.Македоны Битола хотын ЮНЕСКОын дэргэдэх Театр урлагийн институтаас 23 дахь жилдээ зохиогдож буй "А"зэрэглэлийн "One man show" Олон Улсын нэг хүний жүжгийн уралдаант фестиваль 05 дугаар сарын 12-20-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, Аймгийн Монгол Туургатан театрын жүжигчин, Олон улсын "Ялагчдын цуваа 2021" уралдааны Гран при шагналт СТА Р.Янжиндулам Б.Батдэлгэрийн "Би хэн бэ" жүжгээр оролцож " ГРАН ПРИ" шагналын эзэн боллоо. Мөн ОХУ-ын Москва хотноо болсон Нэрт хөгжмийн зохиолч Исаак Дунаевскийн нэрэмжит Олон улсын дуулаачдын XII дахь удаагийн уралдаан 05 дугаар сарын 21-нд зохион байгуулагдаж дуучин Д.Дарьсүрэн оролцож "Ардын дуу" -ны төрөлд ТЭРГҮҮН байр," Академический вокал буюу СОНГОДОГ ДУУРИЙН ДУУ"- ны төрөлд ДЭД байр," Эстрадын дуу"-ны төрөлд ГУТГААР байр шагналын эзэн боллоо.

2.Орчин цагийн хөгжмийн урлагийг үндэслэгч БНМАУ-ын анхны Гавьяат дууч Магсар Хурцын Дугаржавын нэрэмжит уртын дууны Улсын уралдаан 05 дугаар сарын 02-нд зохион байгуулагдаж дуучин Д.Одбаясгалан, СТА Ө.Батцэцэг нар амжилттай оролцож дуучин Ө.Батцэцэг "Дэд байр"-ын шагнал хүртлээ.

3. ГЭГЭЭН МУЗА-17" наадам 05 дугаар сарын 06-нд 1-р шатны шалгаруулалтад Лев. Устиновын зохиол "МОДОН ЗАМ" хүүхдийн жүжиг, Хөдөлмөрийн Баатар, Төрийн Шагналт, АУЗ Б.Лхагвасүрэнгийн "ХООСОН ЗҮҮД" ганц хүний жүжгээр жүжигчин СТА Б. Сүхбаатар тус тус оролцлоо.

4."Odnoo dance studio" бүжгийн дугуйлангийн хүүхдүүдийн "ЖАРГАЛТАЙ ХҮҮХЭД НАС" тайлан тоглолт 05 дугаар сарын 20-нд зохион байгуулагдлаа.

5. 05 дугаар сарын байдлаар дотоодын 8 арга хэмжээнд оролцож, гадны 9 арга хэмжээ зохион байгуулагдаж 5200 үзэгчдэд үйлчилснээс 3500 хүүхдэд үйлчиллээ.

МУЗЕЙН АЖЛЫН ХҮРЭЭНД:

1.Соёлын сэргэлт-2023 аяны хүрээнд Төв аймгийн соёл урлагийн байгууллагууд, Чингис хаан үндэсний музей, урлагийн зарим байгууллагын хамтарсан нээлттэй хаалганы өдөрлөгийг Зуунмод сумын Мөнх алдарын талбайд зохион байгууллаа. Уг үйл ажиллагаанд Төв аймгийн музей нь "Манзуширийн хийд" сэдэвт шашны эд зүйлийн үзэсгэлэн гаргаж иргэдэд хүргэлээ. Үзэсгэлэнгээс гадна Ерөөлч, магтаалч, Монгол улсын хошой мэргэн, Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч Д.Цэдэнсодном шагай харваж үзүүлэн, сонирхсон иргэдээр шагай харвуулан тоглууллаа. Мөн Зуунмод сумын 4-р сургуулийн Монгол хэл бичиг, уран зохиолын багш, Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч Б. Батцэцэг уран бичлэгийн үзүүлбэрийг танилцуулж, үзэгч хүүхдүүдийн дунд түргэн хэллэгийн тэмцээн явууллаа. Тус үйл ажиллагаанд нийт 200 иргэн хамрагдлаа.

2.Олон улсын музейн өдөр "Музейн тогтвортой байдал ба сан сайхны төлөө" уриан дор, "Эерэг хандлага-Эрүүл нийгэм", "Цаг гаргая", "Илүүдэл жингүй– Эртэч төв аймагчууд", "Энэ жилдээ-Эрүүл жиндээ 2023" аяны хүрээнд Төв аймгийн соёлын салбар байгууллагуудын ажилтан албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, нийтийн биеийн тамирыг дэмжин музейн үйл ажиллагааг сурталчилах зорилгоор 4 төрөл спортын тэмцээнийг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд нийт 6 байгууллагын 7 баг тамирчин оролцлоо.

НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ХҮРЭЭНД:

1.Үндэсний оюуны соёлын их өв болсон Монгол бичгээ эрхэмлэн дээдлэх, эх хэл бичгээ зөв эзэмших, хэрэглэх, түүнд суралцах, хадгалан хамгаалах, хос бичигтэн болох, хойч үедээ өвлүүлэх, өөрийн мэдлэг чадвараа сорих, сурах хүсэл эрмэлзэл төрүүлэх зорилгоор "Үндэсний бичиг үсгийн баярын өдөр"-ийг тохиолдуулан төрийн албан хаагчдын хаагчид

болон ЕБС-ийн 8-р ангийн сурагчдын дунд “Эх хэл бидний бахархал” сэдэвт “Алтан үсэг” тэмцээн, ЕБС-ийн 7-12-р ангийн сурагчдын дунд “Уран бичвэр” тэмцээнийг зохион байгууллаа.

2.“НОМЫН БАЯР-2023” арга хэмжээний хүрээнд Мөнх-алдрын талбайд “Шидэт ном бүтээлийн уралдаанд шалгарсан бүтээлийн үзэсгэлэн”, Үндэсний бичиг үсгийн баярын өдрийг тохиолдуулан ЕБС-ийн 7-12р ангийн сурагчдын дунд зохион байгуулсан “Уран бичвэр” уралдаанд оролцсон сурагчдын бүтээлийн үзэсгэлэн, “Босоо бичиг-Бидний бахархал” сэдэвт номын үзэсгэлэнг гаргаж 1500 орчим хүүхэд залуус, иргэд үзэж сонирхлоо. Арга хэмжээний үеэр “Хүүхэд бүр уншигч” уриан дор “Зохиолч уншигчдын уулзалт”-ыг зохион байгууллаа. Уулзалтын зочдоор зохиолч Бямбажавын Баярхүү, зохиолч-Яруу найрагч, зохиолчдын эвлэлийн гишүүн Хишигнямын Дуламсүрэн нар оролцлоо. Уулзалтанд Зэвсэгт хүчний 016-р нэгтгэл, Зуунмод Политехникийн коллеж, ХЦБС-ийн Эрдэнэцэцэг багштай 7г ангийн хамт олон, Нийтийн номын сангийн дэргэдэх “Ертөнц” номын клуб-ын хүүхдүүд нийт 67 хүүхэд, залуучууд, иргэд хамрагдсан. /эрэгтэй-35, эмэгтэй-32/

3.Төв аймгийн түүхт 100 жилийн ой, Номын баяр-2023, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах баярын өдөрт зориулан зохион байгуулсан хөгжөөнт танин мэдэхүйн “АХА” тэмцээнд Нийтийн номын сангийн уншлагын танхимд ирсэн ЕБС-ийн 6-11 р ангийн 30-аад сурагч идэвхитэй хамрагдлаа. Тэмцээний үйл ажиллагааг Аймгийн Засаг даргын ажлын алба, Д.Нацагдоржийн нэрэмжит Нийтийн номын сан, ТВ-9 телевиз хамтран зохион байгуулж Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар тэмцээнд оролцогч хүүхдүүдэд гарын бэлэг гардууллаа.

4.Аймгийн Нийтийн номын сан нь 2023 оны 5 дугаар сард танхимаар 274-н байнгын уншигч, 1943 ирэгсэд, нийт 4754 ном олгож уншуулан үйлчиллээ. Үүнээс: 129 эрэгтэй, 145 эмэгтэй уншигч үйлчлүүлээ.

БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХҮРЭЭНД:

1.МУ-ын Ерөнхийлөгчөөс санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд улс орон даяар зохион байгуулагдаж байгаа “Цаг гаргая” аяны туг дэвтрийг 26 суманд аялуулах ажлыг Эрдэнэ, Алтанбулаг, Баянчандмань сумаас эхлүүлээ.

2.Биеийн тамирын багш нарын сургалт, семинар, олимпиадыг Аймгийн БШУГ-тай хамтран 2023.05.08-09-ны өдрүүдэд зохион байгуулж 27 сумын 61 багш оролцож БТ-ын багш нарын олимпиадад Баянжаргалан сумын багш Б.Батцэнгэл тэргүүлсэн бол, 5-р сургуулийн багш Ц.Золзаяа ХЦС-ийн багш А.Дуламсүрэн нар удаах байруудыг эзэллээ.

3.Хамтдаа дуулъя, бүжиглэе цэнгүүнийг Аймгийн ГБХЗХГ, Нийтийн номын сантай хамтран 2023.05-17-нд Зуунмод сумын Соёлын төвд зохион байгуулж 3 байгууллага, 6 багийн ахмад нийт 100 гаруй иргэн хамрагдлаа.

4.“Цахим гүйлт 2023” арга хэмжээ улс орон даяар зохион байгуулагдаж Төв аймаг 1050 иргэнийг хамруулан 2.262 км зам туулсан амжилтаар улсад 5-р байрт шалгарлаа

5.Төв аймаг байгуулагдсаны түүхт 100-н жилийн ойн хүрээнд домогт их аварга Ж.Мөнхбат агсны хөшөөг Төв аймагт сүндэрлүүлэх шийдвэр гарч хөшөөний шав тавих ажиллагаа 2023.05.22-ны өдөр болж их аваргын гэр бүл, үр хүүхэд, аймгийн удирдлагууд оролцлоо.

Зохион байгуулсан арга хэмжээ:

1.Төв аймгийн 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан хөнгөн атлетикийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2023.05.06-07-нд зохион байгуулж 14-н сумын 180 тамирчид оролцлоо

2.Цэрэг спортын олон төрөлт буюу “Дөл” тэмцээнийг Аймгийн 016-р бригад, Цэргийн штабтай хамтран 2023.05.09-нд зохион байгуулж 8 багийн 104 тамирчин оролцлоо.

3.Аймгийн хүүхдийн спортын VII их наадам, Төв аймаг үүсэж хөгжсөний 100 жилийн ойг угтаж “Шарваа -2023” өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнийг 2 насны ангиллаар 2023.05.12-14-нд зохион байгуулж 14 сумын 15 багийн 600 гаруй тамирчин оролцсон.

4.Үндэсний сурын нээлтийн харвааг нээлттэй хэлбэрээр 2023.05.13-14-ны өдрүүдэд Зуунмод суманд зохион байгуулж 18 аймаг 6 дүүргийн 24 багийн өсвөрийн 12, насанд хүрэгчдийн 128 нийт 140 харваач оролцлоо.

5.МУ-ын аварга А.Сүхбатын нэрэмжит өсвөрийн үндэсний бөхийн барилдааныг 16 настай бөхчүүдийн дунд 2023.05.13-нд зохион байгуулж 8 сумын 64 бөх барилдсанаас Заамар сумын Н.Бат-Өлзий түрүүлж, ХЦСургуулийн Т.Мөнхбаяр үзүүрлэн, ХЦС-ийн А.Бүдгочоо, Жаргалант сумын сурагч Б.Саруултөгс нар шөвгийн дөрөвт шалгарлаа.

6.Цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд “ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЦАГААН ТОЛГОЙ” аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2023-05-15-нд зохион байгуулж 22 цэцэрлэгийн 220 хүүхэд оролцсон.

7.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжүүлэх тэднийг биеийн тамир спортод татан оролцуулах, идэвхтэй хөдөлгөөнд уриалан пара хөнгөн атлетикийн тэмцээнийг 2023.05-16-ны өдрүүдэд зохион байгуулж 5 сумын 49 иргэнийг хамрууллаа.

8.1998-2002 онд ХЦС-ийг төгссөн төгсөгчдийн дундах спортын бага наадмыг 2023.05.20-21-ны өдрүүдэд зохион байгуулж 10 багийн 1200 тамирчид оролцлоо

9.“POLICE GUP-2023” 19 дэх удаагийн пауэрлифтингийн тэмцээнийг 2023.05.19-20-ны өдрүүдэд зохион байгуулж 7сумын 43 тамирчин хамрагдлаа

10.Төв аймгийн 100 жилийн ойн хүрээнд зохиогдсон 2023 оны өсвөр үе, залуучуудын уулын дугуйн улсын аварга шалгаруулах Зуунмод хотод 05-р сарын 27-28-нд зохион байгуулж 12 байгууллагын 110 тамирчин хамрагдаж манай баг тамирчид 1 алт 1 мөнгөн медаль хүртэж багийн дүнгээр 3-р байрыг эзэллээ.

11.Аржанчивлан рашаан сувиллын газрын 50 жилийн ойн нэрэмжит эмч эмнэлгийн ажилтан албан хаагчдын дунд зохион байгуулагдсан спортын бага наадмыг 2023.05.27-28-нд зохион байгуулж 27 сумын 10 багийн 300 гаруй албан хаагчид хамрагдлаа.

Оролцсон уралдаан тэмцээн:

1.Үндэсний шагайн харвааны улсын аварга шалгаруулах 33 дахь удаагийн тэмцээнд 120 баг оролцож Төв сайхан нутгийн Монгол Улсын Үлэмж Дархан Мэргэн с/м Ц.Энхбат ахлагчтай Хийморь багийн харваачид Мөнгөн медаль хүрлээ.

2.Монгол улсын гавьяат тамирчин Д.Нармандахын нэрэмжит олон хотын самбо бөхийн аварга шалгаруулах тэмцээн 2023.05.12-14-нд Орхон аймагт болж самбо бөхийн өсвөрийн шигшээ багийн тамирчид амжилттай оролцож 2 мөнгө, 1 хүрэл медаль хүртлээ.

3.ОХУ-ын Тува улсын Кызиль хотноо жил бүр уламжлал болгон зохиогддог чөлөөт бөхийн “ЦЕНТР АЗИ” олон улсын тэмцээнд Төв аймгийн “ТӨВ АРЖ” багийн залуучууд амжилттай оролцон 1 алт, 2 хүрэл медаль хүртлээ.

4.ОХУ-ын Буриадын Кижинга аймагт болсон ЗХУ-ын баатар Д.Жанаевын нэрэмжит 45 дахь удаагийн олон улсын тэмцээнд өсвөрийн шигшээ багийн тамирчид оролцон 2 алт, 1 мөнгө, 2 хүрэл медаль хүртлээ.

5.Дорноговь аймагт зохион байгуулагдсан жюү-жицү бөхийн аварга шалгаруулах олон улсын тэмцээнд жү-до бөхийн өсвөрийн шигшээ багийн тамирчид оролцож 3 алт, 3 мөнгө, 3 хүрэл медаль хүртлээ.

6.2023 оны Самбо бөхийн залуучуудын улсын аварга шалгаруулах өсвөрийн шигшээ багийн 9 тамирчин оролцож 1 алт, 5 хүрэл медаль хүртлээ.

7.МУ-ын Ерөнхийлөгчөөс санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг дэмжин “Цаг гаргая” аяныг эхлүүлэн нийтийн биеийн тамир, их спортын 96 арга хэмжээнд 5807 иргэнийг хамрууллаа. Улс бүс, олон улсын тэмцээн уралдаанд шагайн харваа, дугуй, чөлөөт, самбо, жү-до жюү-жицү бөхийн төрлүүдээр оролцож 7 алт, 14 мөнгө, 13 хүрэл медаль хүртлээ.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР

Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

1.Хүүхдийн мөнгө зогсоох тухай 1 өргөдлийг хүлээн авч, бүрэн шийдвэрлэсэн. Мөн түр зогсоосон 4 хүүхдийн мөнгөний хүсэлтийг сэргээж 8 хүүхдийн хүүхдийн мөнгийг хэвийн олгож эхлэсэн.

2.Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн 04 дүгээр зөвлөмжөөр Хүүхдийн тоглоомын талбайн хяналт шалгалтыг орон нутгийн Хүүхдийн төлөө зөвлөл зохион байгуулж 19 сумын 36 тоглоомын талбайд 41 зөрчилд илэрч, зөрчлийг тухай бүр арилгуулж ажилласан байна.

3.Хүүхдийн төлөө зөвлөлийн ээлжит хурлаар өдөр өнжүүлэх төвүүдэд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт, саналыг хэлэлцүүлж Хүүхдийн төлөө зөвлөлийн 02 дугаар тогтоолыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

4.Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг Баянжаргалан сумын ЕБС-д зохион байгуулж, 6-9-р ангийн 89 сурагчдад хамрагдлаа.

5.Сурагчдын аюулгүй байдлыг хангах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ухаалаг утасны хэрэглээг бууруулах зорилгоор "Хүмүүн цогцолбор дунд, ахлах сургууль болон 4-р сургуулиудад "Итгэлтэй утас" -ыг байршуулан ажиллуулж байна.

6.Дэлхийн зөн Монгол ОУБ-ын ТОНХ, Монголын Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн Төв аймаг дахь салбар хамтран "Үндэсний аяны нээлтийн арга хэмжээг Ерөнхий боловсролын

сургуулийн дунд болон ахлах ангийн сурагчид, Төв Политехник коллежийн оюутнуудыг хамруулан зохион байгууллаа.

Гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

1.Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас Зуунмод сумын сургуулийн өмнөх боловсролын байгууллагын залуу багш нарт 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр "Гэр бүлийн үнэ цэнэ", "Бага насны хүүхдийн цогц хөгжил" сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтад 20 залуу багш хамрагдсан.

2.Олон улсын Гэр бүлийн өдрийг угтан "ҮЙЛДЛЭЭРЭЭ-ҮЛГЭРЛЭЭ" аяныг 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдөр хүртэл 27 сумын хэмжээнд зохион байгуулж байна.Энэ аяны хүрээнд Төв аймгийн Цагдаагийн газартай хамтран "Гэр бүлийн харилцаа, "Жендэр ба хүйсийн ялгаатай байдал", "Халамжтай аав" сэдэвт сургалтуудыг зохион байгуулсан. Сургалтад 21 эрэгтэй хамрагдлаа.

3.Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн бага, дунд, ахлах ангийн сурагчдын эцэг, эхчүүдэд 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Дэлхийн зөн ОУБайгууллага Төв ОНХөтөлбөртэй хамтран "Мөрөн Үр жимстэй гэр бүл" НҮТББайгууллагын багш "Гэр бүлийн алтан дүрэм" сэдэвт сургалтыг зохион байгуулж 21 эцэг, эх хамрагдлаа.

4.Олон улсын Гэр бүлийн өдөр 05-р сарын 15 өдөр, "ҮЙЛДЛЭЭРЭЭ-ҮЛГЭРЛЭЭ" аяны хүрээнд Залуусын цахим телевизтэй хамтран "Хосын яриа" цуврал контентыг бэлтгэн олон нийтэд хүргэсэн. Контентын анхны дугаарт Зуунмод хотын иргэн Б.Отгонбаяр, гэргий Д.Жаргалтуяа, хувираа хөдөлмөр эрхлэгч И.Алтангэрэл, гэргий Г.Мөнхцэцэгийн хамт оролцсон.

Залуучуудын хөгжлийн чиглэлээр:

1.ИРЭЭДҮЙН ЭЗЭД-2023 мэргэжил сонголтын аяныг 2023.05.03-ны өдөр зохион байгуулагдлаа. Арга хэмжээнд 27 сумын ЕБС-ийн ахлах ангийн сурагчид танхим болон цахимаар оролцлоо.

2.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хууль сахиулах байгууллагуудын "Нээлттэй хаалганы өдөрлөг", "Хуульчийн Про Боно" өдөрлөгийн арга хэмжээний хүрээнд Монгол улсын Иргэний андгай өргөх ёслол"-ын үйл ажиллагааг Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран зохион байгууллаа.

3.Төв аймгийн өсвөрийн сагсан бөмбөгийн аварга шалгаруулах "ШАРАВАА-2023" тэмцээн 15 дахь жилдээ зохион байгуулж, тэмцээнд 14 сумын 600 гаруй тамирчид оролцлоо.

4.Аймгийн Засаг даргын Тамгын газрын НБХэлтэс, Биеийн тамир спортын газар, Залуучуудын хөгжлийн төв, Дэлхийн зөн ОУБ-ын төв орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, ХБИ-ын холбоо хамтран Аймгийн аварга шалгаруулах "ПАРА-2023" хөнгөн атлетикийн тэмцээнийг зохион байгууллаа.Тус арга хэмжээнд Нацагдоржийн нэрэмжит номын сангийн хамт олон номоор үйлчилж, ХБИ-холбоонд ном хандивлалаа. Тэмцээнд нийт 5 сумын 49 тамирчин спортын 6 төрлөөр өрсөлдөж шилдгүүдээ тодрууллаа.

Сэтгэлзүйн ганцаарчилсан зөвлөгөө, ярилцлага-9 хүн, Бүлгийн зөвлөгөө-1 удаа, Нийт-10 удаагийн сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан.

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР